

ТҮҮХИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХҮЙ¹⁷²

I Өрнөдийнхөн амжилтандаа сагсуурав уу?

Зөвлөлт холбоот улс задармагц Өрнөдийн улс орнууд нь Түүхийн төлөөх тулаанд ялалт байгуулж, дэлхийг өөрсдийнхөө дур хүслээр залах боллоо хэмээн бодоцгоох болов. Гэтэл тэр цагаас хойш тэдний ажиглан харж буй ертөнц хүсэн хүлээж байсан итгэл найдвартай нь нэг ч их таарч нийцсэнгүй. Дайнаас хойш дөчин таван жилийн турш үргэлжилсэн Өрнө-Дорнын хоорондох хяслант хүчир тулаанд 90-ээд оны эхээр ялалт байгуулсандаа барууны улс орнуудын оршин суугчид бялуурах нь холгүй болов. Америкийн нэгдсэн улсад л гэхэд оюун санааны сэргэлт нь өөрсдийгөө магтах зүйл болон хувирлаа. Хүн төрөлхтний ашиг сонирхолд нийцсэн “дэлхийн шинэ эмх журам” удахгүй тогтоно гэж Ерөнхийлөгч эцэг Буш ам гарч байв. Тэр он жилүүдэд неоконсерватив үзлээрээ нилээд алдаршиж байсан, америкийн түүхч, философч Френсис Фукуяма, ЗСБНХУ задарснаар Өрнөдөд сөрөн зогсохуйц нэг ч том гүрэн, нэг ч үзэл суртал үлдээгүй тул “түүхийн төгсгөл” боллоо хэмээн тунхаглав. Өрнөдийн үнэт зүйлс болсон зах зээлийн эдийн засаг, ардчилал зэрэг нь дэлхийд ялах нь гарцаагүй зүйл мэт болов. Үүнийг зөгнөсөн мэт 70-аад оны сүүлчээр Хятад улс зах зээлийн эдийн засагт шилжинэ хэмээн Дэн Сяопин зарлаж байлаа. Бүх улс орон либераль ардчилсан зарчмаар хөгжих нь жам ёсны мэт санагдаж эхлэв.

Хүн төрөлхтөнд “иргэншил хоорондын мөргөлдөөн” заналхийлж байна хэмээн 1993 онд профессор Сэмюэль Хантингтоны сануулж хэлсэн нь америкчуудын бардам зан, европчуудын өөдрөг үзэлд эс таалагдан, улс төрийн хувьд харалган, хэт дэвэргэн зүйл гэж тооцогдов. Хантингтон иргэншлүүдийг ангилж: өрнөдийн, латинамерикийн, африкийн, исламын, хятадын, энэтхэгийн, үнэн алдартны, буддын, японы гэж ес хуваажээ. “Иргэншлүүд” олон төрөл төдийгүй, өөр хоорондоо антагонист зөрчилтэй гэсэн ойлголт бүхий Хантингтоны энэхүү ангиллыг үл таашаагсад ч бас байлаа. Бүх хүмүүс ахан дүүс шүү дээ?

Гэтэл америкчууд, дэлхий ертөнцийг тогтвортой, аюулгүй байлгах зайлшгүй нөхцөл бол өөрсдийнхөө манлайллыг тогтоох замаар энэ гаригийг бүрэн ивээлдээ авна гэсэн итгэл үнэмшлээ чухалчилдаг. Гэнэн санаат европчууд хийгээд канадчууд болохоор “энхийг сахиулах хувь ерөөлөө” хурдан гүйцэлдүүлэхийг тэсч ядан хүлээж, дэлхийн нэгдүгээр дайны дараа байгуулагдсан Үндэсний Лиги, Дэлхийн хоёрдугаар дайны дараа 1945 онд байгуулагдсан НҮБ зэрэг шиг итгэл алдруулахааргүй, олон улсын жинхэнэ эв нэгдэл цогцолж, хүйтэн дайныг хална гэдэгт итгэсээр байна. Хамтын шинэ

¹⁷² 1997 - 2002 оны хооронд Францын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан Юбер Ведриний “Түүхийг үргэлжлүүлэхүй” нэртэй номын хэсгээс орчуулан хүргэж байна. Энэ номонд хоёр системийг зааглаж байсан үзэл суртлын төмөр хөшиг нурснаас хойшхи дэлхийн улс төрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, америкийн философч Фрэнсис Фукуяма-гийн “Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн” зохиолдоо дэвшүүлсэн гол санаа болох либераль ардчиллыг цорын ганц зөв улс төрийн хүсэл эрмэлзлэл мөн хэмээх үзлийг эмзэглэнгүй шүүмжлэлт байр сууринаас үзэж өөрийн санаагаа сэргүүлэн тавьсан байна. Тэрээр ийнхүү бичихдээ, даяарчлал, зах зээл, НҮБ-ийн шинэчлэл, дэлхийн нэгдмэл засаглал гэх зэрэг үзэгдэл үйл явцуудтай холбоо бүхий олон янзын төөрөгдлийн учир начрыг тунгаан харуулж, олон улсын чухал асуудлыг шийдвэрлэх зарим гарцыг европ хүний сэтгэлгээгээр уншигч олноо өргөн дэвшүүлсэн юм.

- **А.Энхбаатар**.(ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургуулийн Философи, улс төр, соёл судлалын багийн ахлагч, Доктор (Ph.D), дэд профессор)

нийгэмлэгийн гишүүн бүх улс нь жижиг буурай улс орнуудынхаа дуу хоолойг ч сонсдог, олонхийнхоо ашиг сонирхлыг ч харгалздаг, тийм нийт хүн төрөлхтний шинжтэй гарцаагүй болно хэмээн нөгөөх өрнөдийн үнэт зүйлсийг хуваалцах ёстой болох нь. Зөрүүд, "дайнч" улсуудыг хамтын нийгэмлэгээс шахаж, үнэний замд нь оруулна. Мөргөлдөөнөөс зайлсхийж, НҮБ болон Аюулгүйн зөвлөл үндсэн чиг үүргээ бүрэн гүйцэд хэрэгжүүлж, ноцтой асуудлуудыг шийдвэрлэх болно. Иракийн түрэмгийлэн эзлэлээс Кувейтийг чөлөөлөх байлдааны ажиллагааг эхлэх тухай Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн таван орны 1991 онд санал нэгтэй гаргасан шийдвэр¹⁷³ нь нэг гэлгүй ноцтой мөргөлдөөнөөс сэрэмжилж болдгийг бид бүхэнд харуулав. Иймэрхүү дайны тоог "бүрэн тэглэх"-ийг хичээж, ямар ч л гэсэн өрнөдийн улс орнууд энхийн замаар зохицуулахын төлөө эцсээ хүртэл тэмцэх нь байна. Олон улсын шүүх бүрдэж, нэг ч ноцтой гэмт хэрэгт шийтгэлээс зайлах боломж олгохоо больж, шинэ хэрэг гарахаас сэргийлж чадах болно. Олон улсын иргэний нийгмүүдийн нөлөө өсч, бүх төр засаг тунгалаг, өндөр ёс суртахуунт бодлого хэрэгжүүлэх болж, ингэж чадаагүй тохиолдолд чиг үүргүүд нь төрийн бус байгууллагуудад шилжих болно. Бараа бүтээгдхүүний харилцаа дэлхийг нэгдмэл цул болгож, даяарчлалын хэтийн төлөвийг ч аятайхан болгох нь. Даяарчлалын үр шимээр худалдаан дахь саад бэрхшээл, протекционист хандлага аажмаар алга болно. Улс орнууд өөрсдийн ашиг сонирхлоо тэргүүн зэрэгт тавихаа больж, олон улсын харилцаан дахь түгшүүрт байдал намжиж, үгүй болно. Даяарчлалын ач тусыг бүх улс орон, бүх ард түмэн, бүх хүмүүс (америк даяарчлалын хэллэгээр хэн ч хохирохгүй win-win) хүртэж, Нью-Йорк, Шанхайн томоохон зочид буудлууд дахь хөгжимт үдэшлэг юмуу ресторануудынх нь зоогийн цэсийг санагдуулам, олон үндэстний эклектик, холимог даяар соёлыг бүтээнэ.

90-д онд НҮБ-аас зохион байгуулсан шашины ёслол тахилгуудыг санагдуулам чухал уулзалтуудад зуун ерэн орны тэргүүн оролцов. Эдгээр чуулганаар Хүрээлэн буй орчны асуудал (1992. Рио-де-Жанейро), нийгмийн хөгжлийн зорилтууд (1995.Копенгаген), нийгэм дэх эмэгтэйчүүдийн байр суурь (1995. Бээжин) зэрэг олон чухал асуудлыг хэлэлцжээ. Даяарчлалын асуудлуудыг чухам ийм замаар шийдвэрлэж болох мэт итгэл үнэмшил ч бүрэлдэж эхлэв. Европчууд болон америкийн ардчилсан зарим үзэлтнүүд улс хоорондын уламжлалт хоёр талын харилцаа үе өнгөрөөлөө гэж дуугарах болов. "Робер"¹⁷⁴-д тодорхойлсончлон, Realpolitik-ийг "нэг талаас хүч чадал, бололцооны харилцаанд, нөгөө талаас, үзэл суртлын номчирхлоос татгалзахад үндэслэсэн олон улсын бодлого" гэж үзэх үзэл, XX зуун дахь бүх аймшигт явдлууд түүнээс улбаатай мэт аятай ад үзэгдэх болов. Иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (ОНМХ), шүүх эрх мэдэл, чөлөөт худалдаа, хүний эрх зэрэг "шинэ оролцогч талууд" болон олон улсын харилцааны олон талт тогтолцоог дамжин хэрэгжих ёстой "даяарчлалын асуудлыг удирдахуй"-гаар бодит улс төрийг солихоор шийдэв.

Өөдрөг санаа дэвшүүлэлтийн оргил бадрал нь 2000 оны есдүгээр сарын 8-ны өдөр НҮБ-ын бүх гишүүн орнууд Мянганы хөгжлийн тунхаглалыг баталсан явдал болов. Энэхүү тунхаглалын 32 заалт бүр "НҮБ бол энх тайван, хамтын ажиллагаа, хөгжил дэвшил өөд тэмүүлэх хамаг олны хүсэл эрмэлзлэл гүйцэлдэхэд даян дэлхийд зайлшгүй хэрэгтэй хуран чуулах газар" болохыг ямагт сануулна. Эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэл, хүлцэл, байгаль энэрэл, жигд хариуцлага эд бүгдийг ХХI зууны улс хоорондын харилцаанд

¹⁷³ 1991 оны нэгдүгээр сарын 17-оос хоёрдугаар сарын 28-ны хооронд Кувейтыг чөлөөлж, тусгаар тогтнолыг нь сэргээх зорилгоор АНУ тэргүүтэй олон үндэстний цэргийн хүчин Персийн буланд Иракийн эсрэг хийсэн дайн. Нисэх хүчнийг ашигласан хэмжээ далайцаараа түүхэнд урьд өмнө байгаагүй дээд амжилт тогтоож, "Цөлийн шуурга" нэрээрээ алдаршсан.

¹⁷⁴ Франц хэлний энциклопеди толь

баримтлах суурь үнэт зүйлс гэж тунхаглав. Үнэхээр мундаг мэдэгдэл, уриа дуудлагууд цууриатав!

Өөртөө хэт итгэсэн байдал, дайчин Манихейч үзэл зэрэг нь хойшид олон улсын бодлого гэх зүйл илүүц мэт сэтгэгдэл төрүүлэх болов. Нэгэнт л Өрнөдийн ялалт баттай болсон тул итгэл даахгүй, гэм буруутай дэглэмүүдтэй тохиролцоно гэж юу байх вэ? Харгис дэглэмүүдтэй хэл амаа ололцох гэж нэр нүүрээ бараад яах вэ? Өрнөдийн үнэт зүйлсийг дээдлэх нь гарцаагүй юм чинь эвсэж зохицохын хэрэг юу байна? Анхааруулж, сэрэмжлүүлж, зөрүүд зантнуудад хориг арга хэмжээ авахад л хангалттай. Сөргөлдөөнийг шийдвэрлэх гарцаагүй шаардлага гарах тохиолдол бүрт улс төрчид, дипломатууд Ази, Африк дахь ардчилсан бус, өрнийг эсэргүүцэгч дэглэмүүдтэй, Путины Оростой хүртэл хэлэлцээ хийж, олон нийт, ОНМХ, өрнөдийн төрийн бус байгууллагуудын хурц шүүмжлэл өрнөдөг болов. Яаж та нар энэ мэт иймэрхүү автократуудтай хэлэлцээ хийж чадаж байна вэ? Ийм дэглэмүүдийн юунд нь итгэнэ вэ?

Гэсэн хэдий ч Америк болон Европ дахь иймэрхүү төрлийн төөрөгдлүүд янз бүрийн хэлбэртэй оршсоор. Энэ үзэгдлийг ойлгохын тулд, далайн чанадад үүсч бүрэлдээд хамаг дэлхийд хүчтэй нөлөөлж эхэлсэн тэрхүү үзэл санаа хэрхэн хувьсч ирсэнийг эргэн санах хэрэгтэй.

1989 оноос 1992 оны хооронд АНУ-ын дөчин нэг дэх ерөнхийлөгч эцэг Буш болон түүний баг, тэрчлэн Джеймс Бейкер, генерал Скоукрофт нартай хамт, америкийн манлайллыг бүгд найрамдах намын уламжлалыг сахиж, ямбархаж ёсорхолгүй, прозелитист (*грекийн prosēlytos-ирэгсэд гэсэн үгээс улбаатай. Шинэ итгэл үнэмллийг тунхаглагч үзэл гэсэн утгаар энд хэрэглэжээ.-А.Э.*), давшингүй үзлийн үүднээс сонгодог, бодит, яв цав үнэлгээг өгчээ: Америк дэлхийн цагдаа болмогцоо өөр хэн ч хийж зүрхлэхгүй “цагдах дарга” нь ч бас болчихов. Америкчууд Гельмут Коль, Франсуа Миттеран, Михаил Горбачев нартай эрс шийдэмгий, хариуцлагатай хамтран ажиллаж, ЗСБНХУ задрах үйл явцыг гүйцээж, үзэл суртлаараа хуваагдсан дэлхийн түүхийн сүүлчийн хуудсыг хамхицгаав. Тэд Персийн булангийн дайны үеэр, Кувейтийг чөлөөлөх тухай НҮБ-аас олгосон мандатыг ягштал биелүүлж, уг зорилтоо дуусмагц араб-израилийн сөргөлдөөнийг намжаах асуудалдаа шуурхай эргэн орсон билээ. Билл Клинтон ерөнхийлөгчөөр хоёр удаа сонгогдон ажилласан хугацаанд (1992-2000) америкийн эдийн засаг, улс төрийн хүчирхэгжил оргил үедээ очив. Чухамдаа 1998 оны, Бушийн биш, Клинтоны үе дэх, “супер” гэж урьдын адил тодорхойлж болохоо больсон энэ шинэ үзэгдлийг, муулж магталгүй өөрийн байр сууриа илэрхийлэх үүднээс, “гипер” гэсэн шинэ утгаар нэрлэхэд хүрсэний учир бол “урьд хожид дуулдаагүй” хүчирхэгжсэн тухай бичих болсонд оршино. Гадаад улс төрийн орчинг гойд нарийн мэдрэх (америкийн улс төрчдөд ховор) авъяас, харист төрх, цар хүрээтэй сэтгэлгээ цаанаас нь заяасан ерөнхийлөгч Клинтон Ойрхи Дорнод дахь энхийн үйл явцыг нааштай шийдвэрлэхийг жаахан хожимдсон хэдий ч чинхүү хичээн зүтгэх болов. Энэ бүхэн нь АНУ-д хандах бусад улс орны хандлагыг зөөлрүүлэв. Зөвхөн Цагаан ордонд Билл Клинтон орж ирсэн нь л гэхэд америкийн олон нийтийн санаа бодолд бүрэлдэн эхэлж, ОНМХ-үүдээр болон зарим “судалгааны төвүүд”(“think tanks”)-ийн турхиралтаар цухалзах болсон удирдан чиглүүлэгч байх гэсэн санаархлыг намжааж өгсөн билээ. 1994 онд болсон сенатын болон төлөөлөгчдийн танхимын сонгуульд улам яхир төрхтэй болсон бүгд найрамдах нам ялсан нь Америк хаашаа эргэхийг төвөггүй харуулав. Явцуу царайлсан үндэсэрхэх үзэл цухалзаж, үндэстний ашиг сонирголоо бүхнээс дээгүүрт залж, олон улсын хамтын нийгэмлэгийн ашиг тусын төлөө улс орныхоо эрх ашгийн өчүүхэн хэсгийг золиослохоос айдаг мэт болж, энэ бүхнээс үүдэн, НҮБ-д үл итгэх, холбоотнуудтайгаа харьцахдаа хуншгүй, ивээн тэтгэгч зан гаргах, сөргөлдөөнийг шийдвэрлэхдээ цэргийн хүч хэрэглэх аргыг илүүд үзэх зэрэг шинж тодрох болов. Бүгд найрамдахчууд ялсанаар, Рональд Рейган тухайн цагтаа “America is back”- “Америк эргэлээ” хэмээн томъёолж байснаас ч илүү улс төрийн хатуу бодлого баримтлах нь тодорхой болов. Энэ байдлыг 2001 оны 9-р сарын 12-нд Жорж Уильям Бушийн: “Бид юу хийхээ мэдлээ” гэсэн үг улам баталлаа.

Бүгд найрамдах намын хувирал өөрчлөлтөөс улбаатай бэрх сорилтуудын балаг нилээд эрт эхэлсэн юм. 60-аад онд Джонсоны десегрегаци¹⁷⁵ бодлогод дургүйцсэн өмнөд нутгийн цагаан арьст иргэд ардчилсан намаас үй олноороо хульжиж, Рузвельтийн бүгд найрамдах намд нэгдэцгээсэн нь 30 жилийн дараа барууны популизм руу гудайхад хүргэсэн юм. Тэгэхдээ бүр Библийг үг үсэгчлэн шүтдэг толгойлогчидтой, евангелийн хэт явцуу чиглэлийн популизмд автаж, израилийн барууны үзэлтнүүдийг бүх талаар дэмжих болсон нь америкийн өмнөд нутгийнхны үзэл суртал хийгээд арьсны өнгөөр ялгаварлах уламжлалтай нь харьцуулвал нилээд хачин зүйл болов. Чухам энэ үед бүгд найрамдахчуудын элитүүдийн дунд неоконсерватистууд хэмээн нэрлэх болсон жигүүр үүссэн юм. Чухамдаа ардчилсан үзэлтнүүд, сэхээтнүүд, троиккистууд зэрэг зүүнийхэн байсан тэд нөгөө талд ирэнгүүтээ консерватистууд болсонгүй, харин ч хэт хувьсгалчид болсон нь нэр оновчтой бишийг нотлох ажээ. Хүйтэн дайны үед тэд нар, өөрсдөд нь таалагддаггүй Генри Киссинджерийн намжмал байдлыг тогтоох бодлогыг ЗСБНХУ-д болон Америкийн бүх дайсанд долигнож байна хэмээн ямагт шүүмжилж байлаа. Тэд Рональд Рейганыг бурханы илгээмж мэт дотносон угтаж, эцэг-Бушийн реалист бодлоготой эвсэн найрч байсан бол ерөнхийлөгч Клинтоны улс төрийн төлөвлөгөөг бусниулахын төлөө улайран тэмцэлдэж, хувийнх нь амьдралд хүртэл хушуу дүрцгээв. Клинтон нь Америкийг хүндэтгэхгүй байна, цэргийн хүчээр Саддам Хуссейны дэглэмийг унагаахыг хүсэхгүй байна, Ойрхи Дорнодын асуудлыг шийдвэрлэх үр ашиггүй эрэл хайгуулд улс орны итгэл найдварыг барж байна хэмээн муулцгаав. Дээр нь Левински-ийн дуулиант хэрэг гарч, үйл явдлыг улам бадраав!...

Үнэндээ сенатор Джексон, түүний хамтран зүтгэгч Ричард Перл нарын тойрон хүрээлэгчид болох эдгээр шинэ "неоконсерватистууд" нь 70-аад онд ч тэр, Осло хотод эх суурийг нь тавьсан энхийн үйл явц ид оволцож байсан Клинтоны үед ч тэр Палестины асуудал гэж огт байхгүй, энэ бүхэн бол израилийн зүүний хүчнийхэн болон Израильд дайсагнагч улс орнуудын зохиомол явуулга учраас хөрш зэргэлдээ арабын орнуудыг эвээр эсвэл хүчээр ардчилчихад л тэдгээр улс орон нь өрнөдийн хийгээд израилийн талыг гарцаагүй баримтлах тул асуудал аяндаа шийдэгдэнэ гэж нотолцгоож байлаа. Ингэснээр 1973 онд Менахем Бегины Израильд үндэслэсэн барууны Ликуд-намынхны мөрөөдөл биелж эзэлсэн нутагтаа израильчууд эзэн суух болсон ажээ. Энэхүү жинхэнэ байдлыг үл хэрэгссэн, палестины асуудлыг "ажихгүй" байх оролдлогоо, "Нарийн зааглал, энх тайвныг хадгалах шинэ стратеги" гарчигтай баримт бичигт 1996 онд тусгасан нь өнөөг хүртэл манай гаригийн энэ хэсэг дэх нөхцөл байдалд, Израилийн аюулгүй байдалд, Өрнөд болон араб-исламын ертөнц хоорондын харилцаанд ноцтой уршиг учруулсаар байна.

Ерөнхийлөгч Вильсон 1919 онд Париж хотноо ардчиллыг айлтгаж Клемансо-гийн зэвүүг хүргэснийг уламжилсан мэт, неоконсерваторууд ч бас ерөнхийлөгч Теодор Рузвельт, Уильям Тафт нарын үндсэрхэх үзлийн өв санг өвөрмөц байдлаар сөхөн дэлгэв. Хүү Бушийг ерөнхийлөгч болохоос өмнө Иракийн асуудалд Америк хутгалдаж байх үед энэхүү өвөрмөц ундаанд ардчилсан зарим зүтгэлтнүүд, нэр хүндтэй хүмүүс хүртэл амтшин дурлажээ. Вьетнамын сургамжийг ор тас мартав. Америкчууд ЗХУ задарсны дараа өөрсдийн түүхэн үүрэг, хосгүй "ерөөл" тавиландаа улам гүнзгий итгэцгээв. Олон нийтийн санал асуулгаас харахад, дэлхийг яаралтай ардчилах хэрэгтэй, энэ нь эргэлзэлтгүй хэрэгжих зорилт гэж америкчууд (европчууд ч ялгаагүй) үздэг байна. Ерөнхийлөгч Билл Клинтоны засаг захиргаанд төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан эрч хүчит, эрдэм ухаант эрхэмсэг хатагтай Мадлен Олбрайт "Ардчилсан хамтын нийгэмлэг" байгуулахаар 2000 оны долоон сард Варшав хотноо зуу гаруй орны төлөөлөгчдийг хуран чулуулж бага хурал зохион байгуулж байв. Нэгэнт л бүх ард түмний ирээдүйд зурайх тэрхүү хязгаар нь ардчилал юм бол, тэр тусмаа

¹⁷⁵ Арьсны өнгөөр ялгаварлан тусгаарлахыг болиулах бодлого

Өрнөдөд амьдарч буй хүмүүс энэ бүхний манлайлагч нь бас мөн бол юунд хойш тавина вэ? Олон улсын хэм хэмжээг зөрчиж буй улс орнуудыг цагдаж яагаад болохгүй гэж? НҮБ-ын үйл ажиллагааг сулруулж буй харгис дэглэмүүдийг өөгшүүлж яах юм? Ардчиллыг дэлхий даяар богино хугацаанд амархан түгээж болно гэдэгт тэр үед үнэхээр итгэж байснаа хэдэн жилийн хойно Мадлен Олбрайт дурссан байдаг. Ирак дахь *фиаско* (бүтэлгүйтэл гэсэн итали үг-А.Э.) болтол бүгд ийнхүү бодоцгоож байв. НАТО-г өргөтгөн, НҮБ-ийн “гар хөл” болгон хувиргаж, ардчиллыг даяаршуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүсэл мөрөөдөл америкийн стратегичдын толгойд тэр үед бас төрж байв. Тухайн үедээ энэ бүхнийг нарийвчлан томъёолж, ерөнхийлөгч Эйзенхауэрийн засаг захиргаанд төрийн нөрийн бичгийн даргаар ажиллаж байсан Джон Фостер Даллестай Уинстон Черчилль ярилцахдаа “Англи хэлт ард түмнүүд л гол нь шүү, тэд нэгдэж байж л дэлхийг бүхэлд нь удирдаж чадна” гэж онцолжээ.

Өөрсдийгөө Бушийн эсрэг тууштай байр суурь баримталдаг хэмээн европчууд 2003 онд үзэж байв. Гэтэл үнэндээ тэд Өрнөдийн ардчилах үйл хэргийг бүхэлд нь бүрэн дэмжигчид байлаа. Францын олон нийт л гэхэд “хэрэг явдалд оролцох” өөрийн эрхээ ухамсарлан, ёсчлон гүйцэтгэхийг ихэд чармайж, Бернар Кушнер болон “Хил хязгааргүй эмч нар” амьдралд хэрэгжүүлээд эхлэв. Колончлогчдын “иргэншилчлэх эрх”-ийг хэдхэн арван жилийн дотор цагаатгаад авав. Өрнөдийн дипломатуудын хувьд эн тэргүүний зорилт гэгдэх болсон ардчиллыг идэвхитэй, шулуухан урагшлуулах үйлсэд нь тус дэм үзүүлэхийг өөрсдийн үүргээ гэж ихэнх ОНМХ-үүд үздэг болов. Хүч хэрэглэх асуудлаар америкчууд болон европчуудын үзэл баримтлал нилээд ялгаатай юм. Европчууд 1945 оноос эхлэн, ялангуяа 1989 оноос хойш, универсаль үнэт зүйлс, хэм хэмжээ, хууль ёс, хамтын аюулгүй байдал зэргийг удирдлага болгосон, аливаа сөргөлдөөнийг урьдчилан намжаахыг эрмэлзэн хичээсэн, гай барцадаас салсаны дараахь, түүхжихээс ангижирсаны дараахь (холбооны засаглалыг дэмжигчдийн хувьд бол бүр үндсэрхэхээ больсоны дараахь) төгс төгөлдөр, ардчилсан, амар жимэр ертөнцөд амьдарцгаах боллоо гэж үзэцгээсэн юм. Тодруулж хэлбэл, Өрнөд европынхон л оршин суугч нь байх тийм ертөнцийн тухай тэд мөрөөдөж байсан нь гол санаа юм. Тэд 1990 онд америкийн профессор Джозеф Най-гийн боловсруулсан “Уян засаглал” хэмээх ойлголтыг хялбаршуулсан хэлбэрээр удирдлага болгож байлаа. Гэтэл энд бас авцалдалгүй зөрчил агуулагдах ажээ. Тэд эртний прозелитист үзэл санааны, тэр тусмаа христийн үзлийн нэрийн өмнөөс өөрсдийн үнэт зүйлсээ бусад хүмүүст (“Бүх ард түмэн лүү хүрч очиж, сургах”) хүргэхийг зайлшгүй үйлд тооцож байв. Гол нь хүчээр бус! Харин өнөөгийн европчууд хэлэлцэх, нөхцөл тулгах (муйхарлаж хүртэл), чичилж зангах, дотоод хэрэгт нь оролцох зэргийг боломжтой хэмээн үздэг ч байлдах, эзлэн түрэмгийлэх, бөмбөгдөх зэргээс бүрэн татгалздаг. Хууль ёсны зохих үндэслэл байсан ч хүч хэрэглэхээс европчууд айдаг болжээ. Харин америкчууд болохоор хүч хэрэглэхээс айдаггүй, сөргөлдөөнийг нударгаар зохицуулахыг байж болох төдийгүй (өөрсдөө хүчтэй учраас) зүй ёсны гэж үзэцгээн, хэрэгжүүлэх аргаа сонгох дээр л маргалддаг байна. Ялангуяа хуулийн дагуу олон талаас нь цэгнэсэн шийдвэрд хүрэхийг эрмэлздэг, тийм ч нөхцлийг шаарддаг европчуудаас тэдний ялгагдах нэг онцлог нь “сөргөлдөөн болж буй бүс нутагт ганцаарчлан оролцох”-ыг эр зоригийн хэрэг лугаа бодож, европынхны дээрх байдлыг “мюнхен” сэтгэлгээ хэмээдэг байна. Үүний илрэл нь Иракт цэргээ оруулсан шалтгааны талаар америкийн олон нийт нилээд санал нэгтэй байгаа байдал европынхоны олон нийтийн санаа бодолтой эрс зөрж буйгаас харагдана. Энэ байдлыг 2002 онд Роберт Каган: Марс (Америкийн нэгдсэн улс), Венера (Европын холбоо) хоёрын харшилдаан гэж нэрлэж байв.

**

гийн Өрнөдийн улс орнуудын оршин суугчид, хүч хэрэглэх асуудлаар л ялгаатай суурь баримталдаг болохоос бус, түгээмэл үнэт зүйлс хийгээд ардчиллын тухайд

бол ижилхэн хийрхэлд автан, ялангуяа тэдгээрийг гаднаас нь оруулах (хууль ёсны хийгээд ажил хэрэгч) боломж бий гэж үздэг. XVIII зууны төгсгөл үеэр АНУ, Англи, Франц зэрэг оронд анх дэвшүүлж, 1948 онд Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд дахин баталгаажуулсан суурь эрхүүд бол манай гариг дээр амьдран буй бүх хүмүүсийн хүсэл тэмүүллийн илрэл гэдэг нь ойлгомжтой. Хэн ч, ямар ч соёлыг тээж буй гэдгээсээ үл хамааран, эрх чөлөөгөө хясуулж, хүчирхийлэлд автаж, амь насаа алдахыг хүсэхгүй билээ! Энэ тухай нэрт зүтгэлтнүүд, тухайлбал Нобелийн шагналтнууд болох А.Сен (Амартия Кумар Сен. 1933 онд төрсөн. Энэтхэгийн эдийн засагч. "Хангалуун амьдралын тухай эдийн засгийн онол"-ыг хөгжүүлсэний төлөө 1998 онд эдийн засгийн салбарт олгох Нобелийн шагнал хүртсэн), М.Юнус (Мухаммед Юнус. 1940 онд төрсөн. Бангладешийн профессор, эдийн засагч. "Эдийн засаг, нийгмийн хөгжлийг доороос нь дэмжих үйлс"-ээрээ 2006 онд Нобелийн шагнал хүртсэн), Ш.Эбади (Ширин Эбади. 1947 онд төрсөн. Хүний эрхийг хамгаалагч, Ираны хуульч эмэгтэй. "Ардчилал, хүний эрх, Ираны хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийн төлөө" тэмцсэн үйлсээрээ 2003 онд Нобелийн шагнал хүртсэн) нар болон олон хүн ярисаар байна. Өмнөдийн гэгдэх ард түмнүүд хүний эрхийг ойлгохдоо, өрнөдийн улс орны иргэд жинхэнэ түгээмэл зарчмуудыг өөрсдийнхөө давуу байдлаа бэхжүүлэхийн төлөө зарчмуудтай хослуулаад байна гэж үздэгийг Өрнөдийнхөн болохоор релятивизм (исламын ч юмуу, азийн болон үнэн алдартны үнэт зүйлс)-тай хийж буй тэмцлээрээ халхавчлан олж харахыг хүсэхгүй байна. Эдгээр ард түмэн биднээс ой сайтай, бидний яарч сандран гуйсан уучлалд үнэмших нь юу л бол: Өрнөдийнхөн өөрсдийн зарчмаасаа ухарч, уландаа гишгэлж, "хоёр нүүрт" (өнөөдөр ч мөн үйлчилж буй) бодлого хэрэгжүүлдэг гэдгийг тэд мартаагүй л байгаа. Өөрсдийнх нь үнэхээр түгээмэл хэмээн үздэг эдгээр эрх бусад хүмүүст яагаад тийм харагдахгүй байгааг өрнөдийнхөнд ухаж ойлгох чадвар нэгэнт алга байгаа тул олон нийтийн мэдээллийн хэрэгслээр уухилж цухалдсан дургүйцлээ илэрхийлж, бухимдаж хоцрох л үлдэв. Өрнөдийн үнэт зүйлс дангаараа түгээмэл зарчмуудыг бүгээдэггүй болохыг ираны философч Рамин Джаханбегл, оросын зохиолч Александр Солженицын нар бидэнд зөндөө л сануулсан шүү дээ.

Ардчиллыг, ялангуяа ардчилахыг гэнэн байдлаар ойлгохын аюул нь дээр ярьсан нөгөө л төөрөгдлүүдээс улбаатай оршино. Ерээд оны Өрнөдийнхний өөртөө хэт итгэсэн байдал "ардчиллыг шүтэн бишрүүлэхэд" амархан итгүүлчих мэт төсөөллийг төрүүлсэн нь, хожим ариун номлогч болсон Павел өөрөө христийн шүтлэгтнүүдийг мөрдөн хяхаж байх үед нь Бурхан уулзаж анхааруулсан тэрхүү агшинд тэрээр унаж ойчингоо, гэгээрч, шавьд орсон гэнэн түүхийг санагдуулна. Нотр-Дам дахь баганыг агностик үзэлтэн Поль Клодель гороолоод тойрч явахдаа гэнэт гэгээрсэн гэдэг шиг! Саддам Хусейний дэглэм нурангуут ардчилал тэр дороо тогтчих мэт 2003 онд америкчууд бодож байсан нь, Иран дахь Шахын дэглэм унахад Джимм Картерын хүсч байсан зүйлтэй адил юм. Тэгээд ч Герман болоод Японд 1945 онд байдал ямархуу байсан тухай товхимолуудыг цэргүүдэд тарааж байжээ. Харгис дэглэм сүйрмэгц, ардчилал тогтчихно гэж найдацгааж! Гэтэл Өрнөдөд ч тэр, АНУ-д ч тэр, ер нь хаана ч ардчилал "ганцхан далайлт"-аар бүтээгүй билээ. Сонгогчдын идэвхи суларсан, мөнгө ноёрхсон, лобби дэлгэрсэн, хувийн амьдралд хушуу дүрсэн гэх зэрэг өнөөгийн асуудлаа байя гэхэд тусгаар тогтнох гэж дайтсан, индианчуудаа хүйс тэмтэрсэн, боолчлол хөгжүүлсэн, Өмнөд Умардаараа талцан хядалцсан, хар арьстнуудынхаа сонгох эрхийг хяссан зэргээ мартмааргүй л юм? Европчууд ч гэсэн цус урсгасан хувьсгал, харгис хэлмэгдүүлэлтийн зуунуудаа санамаар юм. Францад л гэхэд 1795 оны сонгуулиас хойш зуун жаран таван жил өнгөрч байж сая нэг юм эмэгтэйчүүд сонгох эрхээ эдлэх болжээ!

Ардчиллыг хаана ч харь гаригийнхан "залсангүй"! Өрнөдийнхөн, ардчиллыг тулгахгүйгээр түгээх ёстой гэж нөгөө Рамин Джаханбегл хүртэл бас хэлж байв. Франц улс нь хувьсгалч байхдаа ч, эзэн хаантай оршихдоо ч, эзэрхэг колони гүрний үедээ ч хаа сайгүй өөрсдийн зарчмыг хүчээр тулгахыг эрмэлзэж, удирдлагын хахир аргуудыг үе үе

хэрэглэж байв. Бүх улс орнууд дахь ардчилал бол удаан хийгээд огцом, үсрэлт хийгээд ухралт, заримдаа нөлөө тус дэмээр, заримдаа гадаад, дотоод хүчний эсэргүүцлээр ер нь л нарийн үйл явцын үр шим болон цогцолдог ч ямагт гүн гүнзгий өрнөдөг жамтай. Мадлен Олбрайттай найрсаг яриа өрнүүлэн сууж байхдаа "Ардчилал бол уусдаг кофе биш" гэсэн маань мексикийн нэрт яруу найрагч Октавио Пас "Энэ ч *Nescafe* биш шүү!" гэж эрт хэлсэн санааг мэдэлгүй давтсан хэрэг байлаа. Ардчиллын сэргэлт (1945 оны дараа: Герман, Итали, Испани, Португали, Грек, Латин америк дахь)-ийг, урьд нь ардчилал байгаагүй юмуу байх аргагүй байсан улс орнууд (2003 оны Ирак, 2002 оны Афганистан)-д ардчиллыг тогтоохтой хэрхэн нэгтгэх; нэгдмэл угсаатны нийгэм (1945 оны Япон)-ийг олон угсаатны нийгэм (Ирак, Африкийн улс орнууд)-тэй нэг түвшинд хэрхэн тавьж жиших; амархан экспортолж болдог ардчиллын технологиуд (иргэний нийгмийн хяналтат сонгууль г.м.)-ыг хүмүүсийн ой ухаанд төлөвших нь маш адармаатай ардчиллын соёлтой хэрхэн уялдуулах зэргийг хэрхэн гарз хохиролгүй шийдэж болох вэ? гэдэгт гол асуудал байгаа юм. Эцэст нь тухайн нийгэмд өөрт нь буй нөөц чадавхид түшин хэрэгжих дотоод дахь ардчиллыг, гаднаас нэвтрэх ардчилалтай хэрхэн хослуулах асуудал бас байна. Гэхдээ гаднын оролцоог урьд нь колони эзэмшигч байсан гүрнүүд юмуу, эсвэл араб-израилийн сөргөлдөөний үед (Картер, эцэг Буш Бейкерийн хамт, харин энд Клинтон хамаарахгүй) цэвдэг сэхүүн аашилж байсан Америк мэт хууль ёсны эрхгүй (гэж арабын улс орнууд үздэг) улс орон хэрэгжүүлэх үү гэдгээс шалтгаалан асуудал улам ээдрэнэ.

Сүүлийн арван таван жилийн турш ардчиллыг загалмайлах гэсэн аяндаа америкчууд, европчуудын зүгээс орос, хятад, араб, африкчуудад хандаж гаргасан тунхаг, мэдэгдэл, хориг, тулгалт зэрэг бүх зүйлийг эргэн санахад, хүрсэн үр дүн нь даан ч маруухан байгаа явдал энэ талаар бас бодох хэрэгтэйг илтгэнэ! Ардчилсан дэглэмийг экспортлох гэсэн оролдлого бүхэн маань ардчиллын соёолжийг гундаах эсрэг үр дагаварт хөтөлж байгааг ойлгох болоогүй гэж үү?

Гэтэл-европчууд (канадуудын хамт), америкуудынхаас тусдаа өөрийн гэсэн төөрөгдөлд автаад байна. Тухайлбал, олон улсын иргэний нийгмийн асуудал байна. Энэ бүтцийн бодит агуулга, хүрээллийг хэн ч нарийн чанд тогтоож хүчрээгүй өнөөг хүрэв. Сонгогчдын тухай юу, санал асуулгад оролцогсдын талаар уу, хэдэн арван мянган төрийн бус байгууллагууд уу, ОНМХ-эрэгслүүд үү гээд ер нь юуг хэлээд байна вэ? Европчууд, канадууд болохоор олон улсын иргэний нийгэмлэг л хүн төрөлхтнийг үндэстэн улсуудын хүрээ хязгаараас чөлөөлж, архаизм, этатизм, хэлмэгдүүлэл зэрэгтэй хийх тэмцэлд аль ч утгаараа бүрэн тохирсон хэрэгсэл (панацея) байх болно гэж үзсээр ажээ. Гэтэл Америкт л гэхэд төрийн бус байгууллага нь эхлээд заавал америкийн алба баймааж дараа нь сая төрийн бус нэрэндээ дүйцдэг төдийгүй, тэнд ч тэр, (Баруун европынхоос бусад) өөр оронд ч ялгаагүй үндэстний тусгаар шинжийг ямагт чухалчилдаг. Бид НҮБ болон олон улсын бусад олон тооны байгууллагууд бол эвсэл зохицлыг бүрдүүлэх хамгийн тохиромжтой талбар, дипломат арга гэж үздэг төдийгүй, өнөөгийн хэлээр бол үндэстний эгоизм гэж нэрлээд буй үндэстнүүдийн ужгирсан ашиг сонирхолыг даван туулах ёс суртахууны тогтолцоо гэж хардаг. Олон улсын шүүх эрхийн нэн тэргүүний зорилт бол аюултай танхай этгээдүүдийг гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, хэрвээ энэ үүргийг биелүүлээгүй тохиолдол гарвал гэм буруутанд ял шийтгэл оноох явдал билээ. Олон улсын шүүх засаглал нь улс төрийн нарийн гүн гүнзгий асуудлыг ч сурмаг гүйцэтгэгч байж чадна гэж (үндэслэл үгүй) үздэг хүмүүс ч мэр сэр байна.

Даяарчлалыг хэрхэн залж удирдах вэ гэсэн "энгийн" асуудал манай гаригийн сайн санаат зүүний хүчнийхний тархи толгойг эзэмдээд байна. Миний хувьд хэт тэнэг (острюмон) мэт санагддаг "Даяарчлалыг удирдах" хэмээх илэрхийлэл бол америкийн эдийн засгаас дэлхий дахинд тулгаж буй даяарших утгаараа, юуны түрүүнд зохицуулалтыг сулруулах уг чанар бүхий тул бүтэлгүй үйлс гэлтэй! Иймэрхүү төөрөгдлийн нэг болох: Европыг их гүрэн гэж, ялангуяа Жак Ширакт илт таалагддаг

дэлхийг олон туйлт хэмээх үзлийг францчууд эрхэмлэн дээдэлдэг нь хачин юм. Энд "Европ гүрэн"-ийг францын төрийн удирдлагыг аажимдаа халах дамжлаг шат лугаа ойлгодог. "Олон туйлт ертөнц" нь америкийн хүчирхэгжлийг хязгаарлахад орших ба манай европ "мэдээж" нэг туйл нь байх ажээ.

Үнэндээ өнөөгийн Америкийн ихэрхэл, Европынхны ахар бодол, Францчуудын идеалист, ужиг заншил зэргийг магтах үг алга. Америкийн хүчирхэгжил, европчуудын гэнэн зан олон улсын эрх зүйг бэхжүүлж чадахаа нэгэнт болив. Мэдээллийн тасралтгүй урсгалд автан аливааг "нэвт шувт харах"-ыг эрмэлзсэн, "биеэр байлцах"-ыг дээдэлсэнийн уршгаар аливаа засаглалд итгэхээ байж, аль ч мэдлэгт эргэлзэх болсон сэтгэлийн хөөрөл давамгайлсан зэргээс болж ОНМХ-ээс "хэт хамаарал"-тай манай нийгэмд, дэлхий дахины хийгээд өөрсдийн ашиг сонирхлын тухай жинхэнэ нөхцөл байдалд нийцсэн бодит төсөөлөлд үндэслэсэн, тууштай, утга төгөлдөр гадаад бодлого хэрэгжүүлэх нь улам бүр хэцүү болж байна. Тэгээд ч бас өнгөц юмуу хийсвэр төлөг зураглалыг удирдлага болгосон улс орнууд нь дотоод бодлогынхоо болоод байнга хувирах олон нийтийн санаа бодлын барьцаа болдог нь байдлыг улам хүндрүүлж байна.

Өчигдөр уржигдар үүсчээгүй энэ байдал улам дордсоор. Киссинджер хүртэл Израилийг, гадаад бодлогоо орхиж дотоодынхоо асуудлыг чухалчилснаас болоод төр засгаа сулрууллаа гэж сануулж байлаа. ОНМХ-ийн нөлөөнд автсан өнөөдрийн ардчиллынхан ч бас ийм байдалд оров бололтой?

Сайн санаа, бат үнэмшил төрүүлсэн, удирдан чиглүүлэгч, халамжлан анхаарагч, өөртөө итгэлтэй хирнээ "хийсвэр бодлого" (irrealpolitik)-оор бүрхмэл өрнөдийн универсализм нь амьдралын бодит ээдрээнд бүдчиж эхлээд байна.

Анх 1995 онд "бүдэрчээ". Израилийн сүүлийн арваад жилийн улс төрийн амьдралд ховорхон заяасан холч ухаант, эр зоригт төрийн зүтгэлтэн Ицхак Рабины амь насыг барууны хэт даврагч хөнөөж, Ойрхи Дорнод дахь Энхийн үйл явцыг мухарлав. Элдэв шалдав шалтагаар мөргөлдөөнийг сунжруулах гэсэн зүсэн бүрийн алан хядагчдад ямар ч горьдлого олгохгүйн тулд "Би энхийн үйл явцыг өнөө өрнүүлэх эсэхээс үл хамааран алан хядлагатай тэмцэнэ, алан хядлага байхгүй байлаа ч энхийг тохинуулахын төлөө тэмцсээр байх болно" гэж цогт зүтгэлтэн Рабин хэлж байв. Эцэг Буш, Джеймс Бейкер нар эхлэлийг нь тавьж Билл Клинтон үргэлжлүүлсэн энхийн үйл явц хэсэг хугацаанд ахиж байснаа, 1996 онд Израилийн ерөнхий сайдаар Биньямин Нетаньяху болмогц мухардалд оров. Нилээд наашлах янзтай болсон хэдий ч боломжийг ашиглаж чадаагүй 2000 оныг эс тооцвол, энэ үеэс хойш урт удаан энхийн үйл явцад найдах итгэл бүрмөсөн хөсөрдөв. Израиль-Палестины сөргөлдөөн нь уулаасаа ч ээдрээтэй байсан Өрнөд болоод исламынхны харилцааг улам хурцатгав.

Бүс нутгийн шинжтэй мөргөлдөөнүүд шинээр нэмэгдэж, шашин мөргөл хийгээд угсаатны бүлгүүд (Балканы хойг, Кавказ, Руанда, энэтхэгийн үндсэрхэх үзэлтнүүд, дахин сэргэж буй улс төржсөн исламизм г.м.)-ийн урьдын сөргөлдөөнүүд дахин сэргэх хандлагатай байгаа нь бүх ард түмэн нийтээрээ найрсан гарцаагүй нэгдэнэ гэсэн үзэл санаанд харшлах болов. 2001 оны наймдугаар сарын 31-ээс есдүгээр сарын 7-ны хооронд Дурбан хотноо арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй тэмцэх асуудлаар чуулсан НҮБ-ын Дэлхийн бага хурлын төлөөлөгчид түүхэн дэх боолчлолын үүрэг роль, түүнээс улбаатай улс төрийн үр дагаврын талаар үзэл бодлоо нэгтгэж чадсангүй! Эдгээр амжилтгүй болсон хэлэлцээрүүд нь өрнөдийн болон африк, исламын орнуудын хоорондох зөрчлийг даван туулж чадашгүй нь гэдгийг өөдрөг үзэлтнүүдэд бас сануулав. 2000 онд хүү Дж. Буш АНУ-ын дөчин гурав дахь ерөнхийлөгч болов. Түүний гадаад дотоод бодлогын талаарх байр суурь, иймэрхүү төсөөлөл үеэ өнгөрөөсөн гэж үзэж байсан европчуудыг гайхшралд оруулсан төдийгүй бас айлгав. 2001 оны есдүгээр сарын 11-ний үйл явдал энх тайван төдийгүй, алан хядлага ч даяар шинжтэй болж буйг илт

нотлов. Өөрсдийгөө халдашгүй дархан гэж үзэж (дэлхий дахин ч бас тэгэж итгэж!) байсан АНУ-д энэ эмгэнэлт явдал гарсанд дэлхий нийт цочирдож балмагдав. Амиа золиослогч алан хядагчидтай аугаа хүчит Америк ч тэмцэж дийлэхгүй нь гэж санагдав! Есдүгээр сарын 11 нь өнгөрсөн хийгээд өнөө хэмээх хоёр бодит байдлыг нягталж тодорхойлсон зүйл биш байлаа. Энэ хэрэг явдлыг Берлиний хана нурсантай ч зүйрлэх аргагүй. Чухамдаа есдүгээр сарын 11-ний үйл явдал нь дэд ерөнхийлөгч Чейни болон неоконсерватористуудад, хүү Бушийн засаг захиргааны угнаасаа манейхист бодлогыг улам миссионист, дайнч, түрэмгий шинжтэй болгоход дэм өгөв. Хүчгүй армитай, ганц хүний дэглэмтэй Ирак орон нь Америкчуудийн хувьд худал баримтаар халхавчлан хүчээ харуулах сонгодог бай болов. Тэд үндэстний бахархлаа гайхуулж, өөрсдийн нефтийн ашиг сонирхлоо өмөөрч, Израилийг дэмжин, ардчиллаар “түрий” барив.

1985-1992 оны хооронд Франсуа Миттеран, Гельмут Коль, Жак Делор нарын удирдлага доор Европын холбоог байгуулах үйлс амжилттай урагшлав. Тэд хоёр туйлт ертөнцийн задрахыг үл хүлээн, Маастрихтын хэлэлцээрийг батлах хүртэл цаг хугацаатай өрсөлдөн өөр (альтернатив) хувилбарыг хайж, Европыг бэхжүүлж байж л гарах ганцхан гарц буйг олж харжээ. Энэ хэлэлцээрийг баталсаны дараа ч ажил хэрэг үргэлжилсээр байв: 1999 оны нэгдүгээр сарын 1-д евро арван нэгэн орны нэгдсэн валют болов; 1995 онд Европын холбоонд шинээр гурван орон нэгдэв; 2004 онд бас арваар нэмэгдэв. Гэвч Ницше хотод холбоонд багтах гэсэн улсын зарим хүрээллийнхэн (Германы хувьд тэгэх шалтгаан байсан байх, харин Францынх ойлгомжгүй) хэлэлцээрт гарын үсэг зурснаар эхэлсэн бүтэцжүүлэх сунгаа мухардалд оров: 2005 онд францчуудын олонхи болох 54.67% -ийн саналаар Үндсэн хуулийн зөвшилцлийг эс зөвшөөрсөн бол голландчууд бүр давж 61.6% нь ийм санал гаргажээ. Европчууд чухам юу хүсээд байгаагаа мэдээгүй бололтой шиг байгаа нь Европ төвтэй олон туйлт ертөнцийг бүтээх үйлийн хэтийн төлөвийг ноцтой бүдэгрүүлэв. Сүржин “Мянганы тунхаглал”-ыг НҮБ-ийн гишүүн орнууд баталснаас хойш долоон жилийг ардаа орхисон, НҮБ-ийн далбаан дор олон хурал чуулган хийж арваад жилийн нүүр үзсэн, Европын үндсэн хуулийг зөвшөөрснөөс хойш гурван оныг үдсэн энэ өдөр дэлхий ертөнц маань “хамтын нийгэмлэг” бас л болоогүй, Европыг л гэхэд нэгдмэл хүчирхэг гүрэн хэмээхэд эрт байна. 192 орны гадаад хэргийн сайдууд болон дипломатууд, олон улсын байгууллагын 120000 түшмэдүүд, олон тооны төрийн бус байгууллагуудын хувьд дэлхий ертөнц маань “хамтын нийгэмлэг” болж, төрөл бүрийн компаниудын ерөнхийлөгч нарт, банкны дарга даамлуудад, тэтгэмжийн сангуудын зохицуулагчид, өмгөөлөгч хийгээд итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт, нефтийн компаниудын ажилтнуудад, зарим ОНМХ-үүд, тансаг загвар болон “world food” зохиогч нарт, урлаг соёлынхонд эдийн засаг маань “даяарчлагдан” харагдах ажээ. Гэтэл жирийн ард иргэд америкжсан даяарчлалын хэврэг бүрхүүлийн гадна талд амь зуусаар!

Бид болохоор, олон улсын хамтын нийгэмлэг дотор оршиж, нэгдмэл түгээмэл үнэт зүйлсийг амьдралдаа хэрэгжүүлж, “шинэчлэгдсэн олон талт байдал”-ын дүрмээр гурав дахь Мянганы “даяар даллага”-д бэлтгэх аядаж, сүүлчийн “тэрс үзэлтнүүд”-ийг либераль ардчилсан хэм хэмжээнд нэгтгэж чадна хэмээн бодоцгоодог. Гэтэл нөхцөл байдал үнэндээ ямар байна вэ?

Олон улсын иргэншсэн хамтын нийгэмлэгээс их зүйлийг бид хүлээж байна. Жинхэнэ байдал дээр энэ ойлголтын цаана улс хоорондын харилцаан дахь нөгөө л хүчний харьцаа далдлаглах ажээ. Тухайлбал, Хятад л гэхэд олон улсын иргэний нийгмийн уулзалтууд дээр (“төрийн зохицуулалттай төрийн бус байгууллага” гэж алдаршсан) төрийн бус байгууллагууд (ТББ)-аа маш овжин “гаргаж тавьж” байна. “Олон улсын иргэний нийгэм” нь илүү эрх дарх хүссэн хүмүүсээр дүүрэн байдгийг үл өгүүлэн, дэлхийн 192 орны 130-д нь ТББ байхгүй, гэтэл байгаагийнх нь хөрөнгө чинээлэг, хүчирхэг харилцаа холбоотой хамгийн томууд нь дийлэнхдээ англисакс хэлт байгууллагууд байдаг юм.

Эвслүүд задарч, гаалийн саад бэрхшээл арилахын хамт дэлхийн эдийн засагт дахин хувиарлалт явагдав. Дэлхийн эдийн засгийн хөгжлийн түвшин нилээд өсөв: 1950 оноос 2003 оны хооронд улс хоорондын худалдааны хэмжээ жилд дунджаар 6% нэмэгджээ. 1975 оноос хойш дэлхийн дотоодын нийт бүтээгдхүүнд худалдаа арилжааны эзлэх хувь 8%-иас 20% болж өсөв. Мэдээлэлд хоромхон зуур нэгэн зэрэг хүрэх боломж бүрдэж, тээврийн үйлчилгээ хямдарч, ачаа зөөвөрлөлт хурдасч байгаа нь дэлхий дахиныг ойртуулан нэгэн хэмнэлд оруулав. Хэрвээ шийдэгдээгүй улс төрийн асуудал болон бусармаг бүх зүйлээ мартан дэлхийн эдийн засгийн (тэр тусмаа ядуу орнуудын хүн амын хэрэгцээг тооцон, тэр бүхнийг бас хангана гэх юм бол санаанд багтамгүй их) өсөлтийн хэтийн төлөвийн тухай, аливаа нэгдэж нийлэх, олж хүртэх хязгааргүй боломжуудын тухай, капитализмын сэргээн босгох, тэр тусмаа аймшигт өвөр хоорондын дайн тулааны ид үед ч хэрэгжихүйц шавхагдашгүй чадварын тухай, өрнөдийн хийгээд зүсэн бүрийн фирмүүдийн дур таашаалын тухай, өнөөгийн “өөрийгөө хөнөөгч эдийн засаг”-ийг экологийн “зам”-д оруулж, ашиг орлогоо зүйрлэшгүй ихээр өсгөх итгэл найдварын тухай бодож чадвал ирээдүй маань өөдрөг харагдаж болох л байх. Гэтэл дэлхийг ингэж харах боломж нь эрс тэрс тэнцвэргүй байдал, ужгирч лавширсан зөрчлүүд, харилцан эвлэршгүй үл ойлголцол, залахад бэрх үл итгэлцэл, өнгөрснөөс улбаатай өшөө хорсол, айдас хүйдэс зэргээс үүдэн маш хязгаарлагдмал бөлгөө.

Хагарлын хил “Умард”, “Өмнөд” –ийг зааглахаа нэгэнт болив. Ядуус, баячуудын хооронд л энэ ангал зураих болов. Ядуурал бүхэлдээ буурах хандлага байгаа боловч, олон улсын санхүүгийн байгууллагууд “вашингтоны консенсус” гэж сүржигнэн зүсэн бүрээр магтан буй, харин Нобелийн шагналт Джозеф Стиглиц болохоор “зах зээлийн фанатизм” хэмээн нэрлэсэн шуурхайчилсан либералчлалаас болоод зарим бүс нутаг (хуучин ЗХУ, африк тив, Латин америкийн зарим улс орнууд)-т нөхцөл байдал хүндхэн байна. Дамын наймаагаар орлогоо огцом өсгөсөн улс орон, бүс нутаг, үйлдвэрийн газар, хувь хүмүүс зэрэг овсгоотой тоглогч нараас болж илэрхий байсан тэгш бус байдал улам ихэссэнтэй хэн ч маргахгүй бизээ.

Франсуа Морен “Зоосоор өрсөн Шинэ Хана” эссендээ бодит эдийн засаг болон санхүүгийн (“хөөсрөл” ч гэж бас болох) хүрээ хоёр хоорондоо маш ялгаатайг тайлбарласан байдаг. 2004 онд улс хоорондын худалдаа бараа солилцоо 8 их наяд долларыг давж, мөн он дахь валютийн зах зээл дээрх худалдаа арилжааны нийт дүн 1155 их наяд доллар болсон нь дэлхий улс орнуудын Төв банкнууд дахь валютийн нийт нөөцийг бараг давжээ. Гэтэл өнөөх зах зээл маань барзгар хэвээрээ, тэтгэврийн болон хандивын сангууд дахь үндсэн хөрөнгийн тавны дөрөв нь татвар цугларахад таатай гэгддэг дэлхийн тийм хэсгүүдэд байршиж буй ажээ. Дэлхийн томоохон банкны эзэд Бока-Рейтон (Флорида муж) –д хуран чуулснаас хойш арван жил ч өнгөрөөгүй атал өөрсдийнхөө зохиосон мөнгөний механизмынхаа ид шидийн учрыг олохоо байв. Ийм “эдийн засгийн казино” нь өөрсдөө дэлхийн хүн амын 2-хон хувь мөртлөө эд баялгийн 50%-ийг эзэмшиж буй хүмүүсийн өндөр орлогыг эрс нэмэгдүүлэхэд үйлчилдэг атал манай гаригийг оршин суугчдын 50%-д ийм баялгийн ердөө л 1% нь оногдож байдаг ажээ. Мянганы тунхаглалд дурьдсаныг үнэн хэмээвээс, 1 тэрбум хүн “туйлын ядуу зүдүү орчин”-д оршиж, 854 сая хүн (хоногт 1900 калориас бага хоол хүнс хэрэглэн) өлсгөлөнд нэрвэгдэж байдгийн 34 сая нь баян чинээлэг улс оронд амь зогоож, амьдарч байна.

Эдийн засгийн даяарчлалыг дэмжигчид ийм аймшигт тэгш бус байдлыг арилгаж болно хэмээн үзэхдээ хүмүүн бодгаль бол эд баялаг, үйлчилгээг адил хүртэгч гэх юмуу, эсвэл америкийн сэтгүүлч Томас Фридманы даяаршин тэгширч “хавтгай” болж буй хэмээсэн. Дэлхий ертөнцийн тив хоорондын гүйлгээний үнийн ялгааг овжин ашиглагч овсгоо сүйхээтэй залуу наймаачинтай зүйрлэн тайлбарлаж байна. Тэдний хувьд хүн бол улс төрийн хамтлагийн гишүүн, тэр тусмаа аль нэгэн соёлыг тээгч бодь сэтгэлтэн байхаа болих ажээ. Тэд мөн чөлөөт худалдааг өмөөрөхдөө хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлдэг хэдий ч тодорхой бус, хяналтгүй “зохицуулалт”-ыг дэмжигч ардчилсан нийгэмчлэл

(экспроприация) иргэн хүнийг юунаас хагацуулж буйг дурьдалгүй өнгөрдөг. Ийм хэлбэрээр даяарчилсаны балаг болох эдийн засгийг эвдэн бусниулсан хор хөнөөлийн талаар хангалттай ярьж ирэв! Даяарчлалын энэ хэлбэрийг ийм гэдгийг хэн ч тооцоолж, үнэлгээ өгөлгүй өнөө хүрч, саяхнаас л эдийн засагчид уг асуудалд ханцуй шамлан орж эхлэв бололтой: ойрын 10 жилд нөхцөл байдал нэг их өөрчлөгдөхгүй бол даяар дулааралтай тэмцэхэд 5500 сая доллар буюу дэлхийн жилийн ДНБ-ий 1%-тай тэнцэх зардал гарахыг Английн лорд Стерн тооцоолон гаргасан байна.

Өөрсдийнх нь ертөнцийг үзэх үзэл болон практик арга барилыг нь шүүмжлээд эхлэхээр америкчууд хийгээд европчууд хэрхэн хүлээж авах бол? Тэд өөрсдийнхөө манлайлагч шинж болон үнэт зүйлсийнхээ давуу гэдэгтээ огтхон ч эргэлздэггүй. Ерөнхийдөө улс төрийн арга барил нь хатуу чанд, эсвэл уян хатан байх талаар л сонголт хийх тухай ярихаас бус, бодит хандлагыг чухалчлах нь юу л бол.

Америкийнх уу, европынх уу гэхгүйгээр, ер нь л бусад бүх хүрээллийнхнээс эдийн засагчдынхыг онцлон авч үзэх хэрэгтэй. Тодорхойлолтоос харахад, тэд дэлхийн эдийн засгийн төлөв байдлыг үнэн дүр төрхөөр нь харж чаддаг төдийгүй, реалист байхгүй бол хол явахгүй нь. Эдийн засагчид бол үндсэн чиг хандлагууд болон өрнөж буй өөрчлөлтүүдийг танадан өөрсдийнхөө сонирхлоор томъёолдог улс. Эдийн засаг болохоор нөхцөл байдалдаа нийцэн тасралтгүй хэрэглэгдэн, даяарчлалаар дамжин нөлөөлөх хүрээ нь өргөждөг жамтай ч, түүний дотоодод капитализмын янз бүрийн талуудын харгис цэвдэг зөрчил тулаан байнга оволздог төдийгүй энэхүү тэмцлийн эхний золиос нь европын нийгмийн тогтолцоо байх магадлал их болж байна. Эдийн засаг нь хүмүүний, соёлын, улс төрийн бодит байдлуудыг үл ойшоох янзтай болов.

Соёл болон салбар дундын, тэр тусмаа улс төрийн хүрээллийнхэн бол дэлхий ертөнцөө ямархуу байдалтай харахыг хүснэ, тийм л байлгахыг эрмэлзэж, уг бодит байдлыг нь утга үгүйд тооцдог улс бололтой. Сэтгүүлчид, улс төрчид ч гэсэн гадаад ертөнцөө харах өөрсдийн үзлээ тулган, (салбар хоорондын тогтолцооноосоо улбаалан!) өөрсдийгөө эцэс төгсгөлгүй магтдаг хирнээ, иймэрхүү идеализмын тарьж буй балагийг өөрсдөө хүлээдэггүй юм. Тэгэхээр тэд биш улс орнууд нь хохирч таарах нь.

Иймэрхүү стратегийг дэмжих хандлага дэлхий нийтээр (Пью-гийн хүрээлэнгийн¹⁷⁶ санал асуулгаас харахад) доошилмогц сандралд орж, америкчууд л гэхэд байр сууриа чангатгаж эхлэв. Тэдний үйлдлүүд нь америкийн үнэт зүйлс, америкийн давуу тал, америкийн гойд шинж, тэрчлэн үндэстний аюулгүй байдлын зайлшгүй шаардлагаар урьдчилан сэргийлэх хориг үйлдэл хийх америкчуудын эрх зэргийг шинээр тогтнуулахад чиглэж байна. Дэлхий нийтийн үйл хэргийг удирдах гэсэн Өрнөдийн ноёрхлыг хэвээр хадгалах тухай энэхүү хатуу чиг шугамыг америкийн неоконсерватистууд төдийгүй европын улс төрчид тэр тусмаа зүүнийхэн бас ихээхэн дэмжиж байгаа юм. Ийм үзлүүдээ ил тод хэлээд байдаггүй ч, нилээд дэлгэрээд амжжээ. “Өрнөдийн эвслийн” хэв загвараар исламын тухай, Орос, Хятадын тухай яриа хөөрөө өрнүүлэхдээ, харилцан буулт хийхгүй байхад хэргийн учир оршиж байгаа юм: АНУ-ын хувьд аюулгүй байдал нь бусад бүх зүйлсээс эрхэм тул манай ардчилсан “үнэт зүйлсийг” улам урагшлуулах, хүний эрхийг хамгаалах талаар ихээхэн чармайлт гаргах хэрэгцээ байна! гэж Бжезинский хэлж байв. Зэвсгээр далайлгах, айлган сүрдүүлэх болон бас хүчээр түрэмгийлэх зэрэг өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалах аргуудын аль нэгнээс нь ч гэсэн татгалзана гэж хэлэхэд түвэгтэй байна. Чухамхүү ийм л бодолдоо хөтлөгдөн, Япон, Австрали, Өмнөд Солонгос, Израилийг НАТО-д элсүүлж, Афганистанд хэрэгжүүлсэнтэй адил, ердийн идэвхитэй үйл ажиллагааны хүрээнээс зайдуу орчинд дайтах чадвартай “ардчилсан эвсэл”-ийг бүрдүүлж болно гэж найддаг мэр сэр улс бас байсаар байна.

¹⁷⁶ 2000-2006 оны хооронд Англид гэхэд 83%-иас 56%, Францад 62%-иас 39%, Германд 78%-иас 37%, Туркэд 75%-иас 30%, Индонезид 75%-иас 30% болж тус тус буурсан үзүүлэлт гарчээ.

Гэтэл энэ бүх бодол санаа, үг яриа бодит байдалд тулаад зогсдог. Нэгдэх нь стратегийн бодит байдал: 2006 оны 11-р сард болсон завсрын сонгуульд Ирак дахь бүтэлгүйтлийн уршгаар бүгд найрамдахчууд ялагдсаны дараа Ерөнхийлөгч Бушийг, бусдын санаа бодол, зөвлөгөөг сонсдог болгож, прагматик байхад зайлшгүй хүргэв. Үнэндээ Иракт дайн хийхийг ардчилсан намынхан альтернатив сонголтгүйгээр бүрэн дэмжицгээсэн улс бөлгөө. Магадгүй тэдэнд хэтэрхий эрт байгуулсан ялалтандаа харамсах цаг ирж мэднэ. Хоёр дахь нь эдийн засгийн бодит байдал: хөгжиж буй улс орнууд, бас Энэтхэг, Хятад, Бразили, Өмнөд африк дахь олон үндэстний үйлдвэрүүд гэсэн шинэ оролцогсод бий болсон нь өрнөдийн давуу талыг нураах бус хадгалах зорилго бүхий даяарчлалын өөрийнх нь шинж чанарыг өөрчилж эхлэв. 2006 оны байдлаар ийм төрлийн 500 үйлдвэрийн 39 нь хятадынх (Бээжингийнхэн энэ тоог 2010 онд 50 болгоно гэж хүсцгээж байна), 19 нь энэтхэг, орос, бразилийнх бөгөөд өмнөд африк, мексикт ч бас олон үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр л гэхэд гадаадын хөрөнгө оруулалтын 37%, хувь нийлсэн болон олж босгосон хөрөнгийн 15% хөгжиж буй орнуудад оногдож байна. Энэ байдалд хятадын экспортын өсөлтөнд тэвдэж буй АНУ дургүй байна. Олон арван жилийн турш дэлхий ертөнцийг өөрчлөн буй чөлөөт худалдааг дэмжигч нь америкчууд байсан бол одоо байдал өөрөөр эргэв. Сенатын энэ онд шинэчлэгдсэн 14 суудлын 12 нь чөлөөт худалдааг эсэргүүцэгч ардчиллынханд оногдов. Чөлөөт худалдааны уршгаар ноцтой балаг амсаж болзошгүй штатуудаас сонгогдсон төлөөлөгчид болон сенаторууд сэргийлэх хориг шинээр тогтоохыг санал болгох болов. Бүгд найрамдахчууд болон клинтоны "сунгааны" ардчилсан нөхөд нь чөлөөт худалдаа АНУ-д ашиг шимээ өгнө гэдэгт итгэсээр байна. Нөгөө талаас, (олон зуун тэрбум доллар) зээлийн хэмжээгээрээ АНУ-ын хөрөнгийн санд тогтоогоод буй Хятадын эрх мэдэл Вашингтоныхныг сандраах болов. Хятадыг (Клинтон шиг) түншээ гэх үү, (Буш шиг) стратегийн өрсөлдөгчөө гэх үү эсвэл (ОНМХ, ТББ зэргээр дамжуулан) хүний эрхийн төлөө тэмцэл өрнүүлэх зайлшгүй шаардлагатай нутаг орон гэх үү гэдэг дээрээ будилж эхлээд байна.

Европын олон нийт ч гэсэн өнөөдөр Берлины хана нурсаны дараахь байдлаас өөрцгч сэтгэл түгшицгээж байна: дэлхий ертөнц бол өнөөх ариун дагшин "олон улсын хамтын нийгэмлэг" биш гэдэг нь илэрхий болсоор. Гэтэл европчууд болж буй өөрчлөлтөд хөшүүн хойрго, эв түнжингүй хандсан хэвээр: тэд "уян хатан засаглал"-ыг хадгалах замаар аюулгүй байдалд илүү анхаарч, өөрсдийн "үнэт зүйлсээ" бэхжүүлэхийг эрмэлзсээр байна. Тэгэхдээ, Хятадад аэробусаа худалдах аа болих, арабуудаас нефть, оросуудаас хийн түлш авахаа түдгэлзэх тэр хэмжээнд арай хүрчихээгүй л байна. Тэд гадаад бодлогынхоо төвд ёс зүйн асуудлыг гол болгохоо зарлах замаар урьдын болон шинээр бий болох аюул заналаас тивээ хамгаалж, аливаа асуудлыг шийдвэрлэж чадна гэж итгэсээр байна. Гэвч иймэрхүү мэдэгдэл итгэл төрүүлэх нь үеэ өнгөрөөж, кантын ёс зүйн үзлийг баримтлагчдыг егөөдөж "Цэвэрхэн гартай гэсэн тэд чинь гаргүй юм байна шүү дээ" гэж Пеги хэлсэнийг санагдуулна. Энэхүү зөрчилт шинж нь европын улс орнуудын хүн амын дотор, элитүүдийн дунд түгшүүр эргэлзээ төрүүлж амой.

Дэлхий ертөнцөө хэрхэн сайхан болгох вэ?

Хуурмаг төсөөллөө залруулах нь тавьсан зорилгоо орхи гэсэн хэрэг биш. Тэгэхээр шилдэг, шударга, итгэл даах ертөнцийг хэрхэн бүтээх вэ?

Ингэхийн тулд зайлшгүй мөрдөх ёстой зүйлсийг НҮБ-ын тунхаглалд: хүмүүс чөлөөтэй хөгжиж, аз жаргалтай амьдарцгаахын тулд, манай гаригийн бүх хүмүүс нэгэн хамтын нийгэмлэгийн гишүүн гэдгээ мэдэрч байхын тулд, хүмүүсийн онцлог шинжийг хамт олноосоо гадуурхагдах, доромжлуулах үндэслэл болгохгүйн тулд, хүмүүс ирээдүйнхээ төлөө хамтдаа бодогдоож, "даяар асуудалд" хүн төрөлхтний ашиг тусд нийцүүлэн хамтдаа хариулахын тулд бүх хүмүүсийн эрхийг хүндлэх явдал гэж дурьдсан байдаг.

• Бид ядуурлыг алга хийж, дэлхий нийтийн дулаарлыг зогсоож, хүний эрүүл мэндэд

хортой химийн аюулт бодисуудыг халах ёстой болж байна. Цэвэр агаар, ундны усны хомсдолтой тэмцэх, үй олныг хамарсан өвчин эмгэгээс сэргийлж, эмчлэх, хөнөөлт зэвсгийн тархалтыг хазаарлах, далд эдийн засгийг үгүй хийж, зохион байгуулалттай гэмт хэргийг устгах, соёлын олон янз байдлын төлөө тэмцэж, соёлын түвшний талаар дундачлах үзэл баримтлалыг эсэргүүцэх, терроризмтой эрс тэмцэх, "иргэншил хоорондын мөргөлдөөн" гаргахгүй байх зэргийг зайлшгүй хичээх ёстой болж байна.

Хүмүүн зоны нэг хэсгээр, нөгөө хэсгийг нь дарангуйлахыг хүсэгчид хийгээд хэт даврагсдаас бусад бүх хүн энэ бүхнийг хүсдэг бус уу? Тийм бол энэ хүслэнг яаж бүтээх вэ? Нийтийг хамарсан үзэл суртлыг төлөвшүүлж байж, хүн төрөлхтний ирээдүйг баталгаажуулна хэмээн олон хүн XIX болон XX зууны турш бодоцгоож байв. Гэтэл бөөнөөр хорих газар, үхэл хагацал, үгүйрэл хоосрол л бүтээв. Дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас жаран жилийн дараа, Хятад дахь Дэн Сяопины агуу их "капиталист" эргэлтээс гучин жилийн дараа, Берлины ханыг нурааснаас арван найман жилийн дараа өнөөдөр байдал ямар байна?

Зах зээлийн эдийн засаг нь өнөөдрийн хувьд ноёлогч, бараг цорын ганц үзэл суртал болчихоод байна. Хүн төрөлхтний түүхэнд хүний хэрэгцээг хангах бүтээгдхүүн үйлдвэрлэлийнхээ тоогоор өнөөгийнхтэй эн зэрэгцэх эдийн засгийн нэг ч тогтолцоо байгаагүй гэж энэ үзлийг дэмжигчид нотолдог.

Либерал үзлийг номлогчид болохоор, нийгмийн хувьд юу сайн, юу муу болохыг тодорхойлох цорын ганц арга бол зах зээлийн эдийн засаг мөн гэж дүгнэцгээж байна. Гэтэл сүүлийн хорин таван жилд нилдээ мөнгөжиж суларсан эдийн засаг нь өмнөх холимог эдийн засагтай ч тэр, хуучны даруухан "вестфаль"-ийн капитализмтай ч бас огт төсгүй ажээ. Шинэ систем нь үйл ажиллагааныхаа нийгэм, хүн хүч, байгаль, эд хөрөнгийн зардлын ихэнх хэсгийг нийгэмд даалгах замаар ашигт ажиллагаагаа хангадаг. Джозеф Стиглицаас эхлээд Жан Пейрелевад нарын бүх хүмүүс энэ эдийн засаг дахь санаанд багтамгүй өөрчлөлт, шилжилтүүдийн талаар дуу дуугаа авалцан ярьж байна. Хэрвээ үйлдвэрүүд төлөвлөгөө тооцоо хийхдээ гадаад зардлаа тооцдог байсан бол тэдгээрийн ашигт ажиллагаа эрс өөрчлөгдөж, зах зээл ч гэсэн ажил хэргийн нөхцөл байдлыг нилэнхүйд нь, баталгаатай харуулах үзүүлэлт болон агшин зуур хувирах билээ. Гэтэл энэ бүхэн байхгүй тохиолдолд, Милтон Фридманы сэдэж, Рональд Рейган, Маргарет Тэтчер нар дэлхий даяар түгээсэн (төрийн оролцоог чухалчлагчдыг төдийгүй, аядуу зохицуулалтыг дэмжигчдэд ч огт таалагдаагүй) "либеральчлах давалгаа" улс орнуудыг, нэн түрүүн азийн хөгжиж буй улсуудыг "бүрхсээр" байх болно!

Чухамдаа, ЗХУ задарсан 1991 оноос эхлэн арван таван жилийн турш, дэлхийн эдийн засгийг либеральчилж байна. 1995 онд Худалдаа, тарифийн Ерөнхий хэлэлцээрийн халааг Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) авав. Энэ байгууллагын гишүүний тоо байнга өсч, 2006 оны төгсгөл гэхэд Вьетнам элссэний дараа зуун тавь хүрч, худалдааны хэмжээ нь үйлдвэрлэлийнхээ өсөлтөөс түрүүлэх болсонд санхүүгийн бүтээгдхүүнээс үүсэлтэй зах зээл дээрх зохиомол дамлан худалдаа маш том үүрэг гүйцэтгэжээ. Манай гаригийн олон хүн энэхүү систем нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж, нийгэм, экологи, улс төрд улам их дарамт учруулж, уг системээс үүдэлтэй ашиг хайх хомхой сэтгэлийг зогсоож чадахгүй гэдэгтэй санал нийлэх боллоо.

Дэлхий даяарх умардын социаль-демократууд, антиглобалистууд, францын социалистууд гээд бүх зүүний хүчнүүд нь өөр хоорондын ялгаа, үзэл бодлын зөрүү зэргээсээ үл хамааран дэлхийг улам төгс болгох зайлшгүй шаардлага байна гэдэг дээр санал нэгдээд байна. Гэтэл тэд бас зах зээлийн эдийн засгийг нийгэм, экологи, философийн талаас нь шүүмжилж, арай өөр хувилбарыг эрэлхийлдэг нэг хэсэг байхад энэхүү эдийн засгийн суурь зарчмуудыг хүлээн зөвшөөрч, янз бүрийн арга хэрэгслээр зах зээлийн хүрээ хязгаарыг улам тодорхой болгохыг зорьсон өөр хэсэг гэж дотроо ялгардаг байна.

Зах зээлийг хэрхэн үзэх талаар антиглобалистууд байр сууриа хараахан тодорхойлоогүй л байна. Албан ёсоор хөдөлгөөн болсноо 1999 онд Сиегт хотод тунхаглаж, улмаар олон улсын уулзалтууд (Порту-Алегри, Генуя хотуудад хуралдаж, Дэлхийн нийгмийн форумыг үндэслэн) зохион байгуулж, зах зээлийн эдийн засагт сөрөн зогсохоо мэдэгдэж, альтернатив зам буюу "Ертөнц өөр байх боломжтой" гэсэн уриалга дор нэгдсэн билээ. Антиглобалистуудын дургүйцэл шинэ биш хэдий ч, зөв зүйтэй юм. Тэд капиталист системийг шүүмжлэхдээ дотоод зөрчлийг нь онцгойлон дурьдаж, нийгмийн ашиг сонирхол болоод хүрээлэн байгаа орчны асуудалд хахир хандсан, зөрчил тэмцэл, өрсөлдөөн мөргөлдөөний эх сурвалж болсон "цэвдэг сэтгэл"-ийг нь уудлан харуулдаг байна. Антиглобалистуудын зарим санал, ийм дүгнэлтүүдийг зөвшөөрөхгүй байж яаж болох вэ? Харамсалтай нь антиглобалистуудын эрээвэр хураавар эвсэлд, зах зээлийн эдийн засагт сөргүүлэн тавих боломжит хувилбарыг дэвшүүлэх нь байтугай, орчин үеийн ертөнцийн өөрчлөгдөн хувирах чадвар хийгээд хүрээ хязгаарыг ухаалгаар үнэлэх чадал тэнхээ хомсдох янзтай нь илт байна.

Төрийн зохицуулалтыг улангасан эсэргүүцэгч (даяарчлал нь зохицуулалтыг үгүйсгэгч мөн чанартайг давтан хэлье) либералиуд болон эдийн засаг дахь ийм зохицуулалтыг дэмжигчдийн хооронд завсрын байр суурь баримтлагчид болох худалдаагаар дамжуулан даяарчлалын үйл явцыг удирдах боломжтой гэж үзэгчид, зах зээлийн эдийн засгийг хүлээн зөвшөөрөхдөө, нарийн дэг журамд нийцэн хэрэгжих ёстойг чухалчилдаг байна. Үйлдвэрийн газрууд (корпорацийн удирдлага), улс орны дотоодод (олон тооны тогтоол шийдвэрүүд), Европын (өрсөлдөөний хуулиуд) болон олон улсын (ДХБ-ын хүрээнд) зах зээл дээр дэг журмууд үйлчилж л байна. ДХБ-ын даргын албан тушаалд сонгогдсон Паскаль Лами эдгээр дүрэм журмыг нэгтгэн зангидах талаар нилээд хүчин чармайлт гаргаж, олон улсын янз бүрийн байгууллагуудын үйл ажиллагаа улам эвсэг болно гэдэгт ихээхэн найдаж байна.

Төрөөс гадна үндэстний болоод төрийн бус байгууллага, хүрээлэнгүүдийн оролцоотой зохицуулалт зайлшгүй талаар ярьж буйг онцлон тэмдэглэе. Даяарчлалыг "зохицуулах" тухай, яг үнэндээ удирдах тухай яриа нь "зөв зохицуулалт", корпорацийн удирдлага гэх зэрэг түүний төрөл зүйлүүдийн тухай, өөрөөр хэлбэл, улс төр, эдийн засгийн бүх засаглал, тэр тусмаа төр засаг хүртэл удирдлага болгон мөрдөх ёстой гэж англи-сакс хэлтнүүд анх боловсруулж үйлдвэрлэл эрхлэхдээ хэрэглэсэн дүрэм журмуудын эмхтгэлд хамаарах юм. Энэ нь ардчиллынхныг ноцтой өдсөн хэрэг мөн. 1999 онд Лионель Жоспений саналаар зогсоосон хөрөнгө оруулалтын тухай олон талт хэлэлцээр нь төрийн (үйлдвэрүүдэд хамаарах) чухал эрхүүдийг хасч, "маргаантай асуудлыг ямар ч нөхцөл тавилгүй олон улсын шүүхээр шийдвэрлүүлэх" үүрэг болгон хувиргасан нь төрийг үйлдвэртэй нэгэн зиндаанд аваачиж тавих болж, ингэснээр төрийн гол онцгойлох шинж болох, шүүх эрх мэдлийг огт өөрөөр үзэхэд хүргэж мэдэх юм.

"Зохицуулалт"-тай уялдан ноцтой асуудал үүсдэг нь: шинжээчдийн бүлгүүд, эдгээр корпорацуудын хянагчид болон өөрийгөө зохицуулах албадын бүтээсэн дүрмүүд нь зохицуулах ёстой бүтээгдхүүн болоод үйлчилгээний зах зээлийн хүрээнээсээ удаж төдөлгүй халиад эхэлдэг явдал. Тэгэхээр, европын том зах зээлийн дотоод дахь өрсөлдөх эрх нь Европын шударга ёсны шүүх болон Өрсөлдөөний Ерөнхий зөвлөлийн тайлбарлаж буйгаар оролцогч орнуудын эдийн засгийн тогтолцоо хийгээд нийгмийн амьдралд нөлөөлж эхэлдэг байна. ДХБ-ын худалдааны дүрэм журам нь Маргаантай асуудлыг шийдвэрлэх хороо болон Чөлөөт худалдааны тухай гэрээ хэлэлцээр зэрэгт дөрөөлөн бараа эргэлтийн хүрээнээс халин гарч дэлхий ертөнцийн амьдралыг төлөвшүүлэхэд хүртэл оролцож эхэлдэг байна. Монтескье-н ёс суртахуунжуулах үйлсэд ("зөөлөн ааль", "зөнгөөрөө л амар амгаланг авчирна" гэдэгт) итгэсэн нөхөд хувьсал өрнөчихсөн мэт баярлацгааж, худалдааны олон зуун гэрээг үзэглэсэндээ хөөрч, хөгжлийг худалдаа л хангаж байна гэж үнэмшин, хүн төрөлхтний жаргалант ирээдүй бүтнэ гэх боллоо. Доха-д байгуулсан анхнаасаа бүтэл муутай олон талт худалдааны хэлэлцээрүүдийг тэд нар сүйрэл зөгнөсөн хэмээн нотлох ажээ. Эдгээр хэлэлцээрийг есөн

сарын 11-ний дараахнаас хэд хэдэн үе шаттай байхаар Дэлхийн хамтын нийгэмлэг 2001 онд эхлэсэн нь "Терроризмд орогнол үгүй"-г даяар олноо мэдэгдсэн аятай болсон юм. Хачирхалтай нь антиглобалистуудын зарим нөхөд өөрсдийнх нь сэтгэлд нийцдэг дэлхийн засаглалын тухай яриа өрнөх үед "удирдуулчих шинж"-ийг хүлээн зөвшөөрдөг хэсэг хүмүүстэй дуу дуугаа авалцан нэгдэх ажээ. Мөн чанар нь угаасаа л бүх нийтийг хамрах нь ойлгомжтой (тоталитари) үзэл санаа, зүүнийхний хүрээлэл дунд орших бүх нийтчлэх үзлийг үргэлж эсэргүүцэгч (антитоталитари) хүсэл тэмүүлэлтэй хэнбугайг ч гэсэн байлдан дагуулах чадвартай байдгийг ойлгоход бэрх! Юун дэлхийн засаглал? Юуг тэр эрхлэх болж байна? Хэн түүнийг томилох хэрэг вэ? Хэн хэнээс бүрдэх вэ? Хэн хянах болж байна? Хэрвээ ийм засаглал хэлмэгдүүлээд эхлэвэл түүнийг шүүмжлэгчид хаана орогнох болж байна, Саран дээр үү? Иймэрхүү асуултууд үүсэхгүй гэж үзье. Тэгвэл НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ДХБ болон ОУВС-ийн захирал-захирагч нарын хамтын удирдлагын тухай яриад байна уу? Эсвэл хаа чуулсан газар нь антиглобалистууд жагсаж эсэргүүцэж байдаг "Их наймыг" хэлээд байна уу? Тийм бол маш аюултай тэнэглэл болно.

Ямар ч тохиолдолд дэлхийн засаглал юу ч долоолгохгүй. Дэлхий дээрх бүх хүчийг "удирдуулчих шинж" нь ч тэр, америкийн "их гүрэн" ч тэр хазаарлаж эс чадах бөлгөө. Хэн ч тэр, аль нэг байгууллага ч тэр өнөө хийгээд ирээдүйд бүхнийг хянаж бас эс чадах болой. Гэтэл зах зээл л ингэж хүчрэх нь асуудал ургуулаад байна.

Дэлхийг улам сайхан болгож өөрчлөхийг хүсэгчид ганцхан зах зээлээр сэтгэл ханахгүй ажээ. "Дэлхийн засаглал"-ын мангас саварлахаас эмээж, "удирдуулчих шинж" болон "ардчиллаар далайлган нийгэмчлэх" (демократическая экспроприация) зэргээс толгоомжилж, "олон талт шинж" дээр л тогтов бололтой. Алдарт Мянганы тунхаглал нь "НҮБ-ыг хүчирхэгжүүлэх" гэсэн төгсгөлийн VII бүлэгтээ, тус байгууллагыг "улам үр шигтай хэрэгсэл болгох", НҮБ болон Бреттон-Вуд (Дэлхийн банк ба ОУВС)-ийн үрээлэнгүүд ДХБ-ын хамтын ажиллагааг сайжруулах талаар дурьдсан байдаг.

Олон талт байдал нь үндэстний явцуу хандлага, өөрсдийн ашиг сонирхлоо чухалчлах эргээс татгалзаж, улс хоорондын хамтын ажиллагаанд уриалдаг. Сүүлийн жилүүд дэх Зушийн засаг захиргааны ганцаарчилсан тоглолт хийх гэсэн бүдүүлэг, өдөөн хатгасан шинжтэй хүсэл эрмэлзлэл улс хоорондын холбоо сүлбээ тогтоох үзэл санааг эсрэгээр харин ч бадрааж, энэ нь иракийн кампани балран унасаны дараа бүр ч идэвхижих болов. Гэвч энэ аргын ноцтой дутагдал сул талыг, түүнийг баримтлагчид нууж хаасаар байна. Тэд НҮБ, түүний зуун хорин зургаан салбар болон дэд хороо, комиссууд, тэрчлэн Бреттон-Вудийн хүрээлэнгүүд, ДХБ зэргийг төгс төгөлдөр болчихсон мэт боддог. Олон улсын тогтсон заншлаар, аливаа байгууллагын гишүүн орнууд нөхцөл байдлаас хамааран санал нэг, эсвэл олонхийн саналаар шийдвэр гаргадаг ёстой. Энэ үйлс нь нарийн, хүчир хөдөлмөр шаарддаг, тэгээд ч 150 (ДХБ)-иас 192 (НҮБ) гишүүнтэй байгууллагуудын хувьд бол бүр ч хэцүү нь мэдээж. Хорин долоон гишүүнтэй Европын холбоо ч энэ л зарчмыг баримталдаг. Бусад төрөлжсөн байгууллагууд ийм хэдий ч, ОУВС л санал хураах өөр тогтолцоотой юм. Гол төлөв олон талт хэлэлцээрүүд оролцож буй улсуудын тооноос хамаарч хүндрэл бэрхшээлтэй учирдаг бол зарим байгууллагад баримтлах дүрэм журмаас ийм байдал үүсдэг байна (бид сүүлчийн дөчин жилийн турш суверенитет хэмээх үзэгдэл дэлхий даяар хэрхэн түгэж буйг ажиглаж ирлээ). Ийм журам мэдээж эвгүй зүйл, гэхдээ л тухайн улсын зарчмын зөвшөөрөлгүйгээр төрийг нь үл хэрэгсэн хориг тавих (право *вето*) эрх эдлэх нь ёс бус болой!

Энэ байдлыг бүгд л мэддэг. Гэвч хүндрэл бэрхшээлийг хэрхэн арилгах вэ? Төр гүрнүүд нь бүрэн бие даасан тусгаар тогтнол (суверенитет)-ыг хязгаарлах ёстой юу, цаашид ч энэ байдал үргэлжлэх үү? Ерөнхийдөө төр гүрнүүд суларч байна. Ихэнх нь эдийн засгийн даяарчлалтай учраа олж чадахгүйгээс болж ийнхүү үйлс нь доройтож байна. Тэд өөрсдөд нь оногдсон засаглалын бүрэн эрхийн зарим хэсгээс даяарчлалтай хөл

нийлэх хийгээд Вашингтон, зах зээл, гадаадын хөрөнгө оруулалт зэрэгт таалагдах нэрийдлээр сайн дураараа татгалзаад байна. Хамгийн овсгоотой хийгээд хамгийн сул дорой улс орнуудад ийм байдал нүүрлэж, улам дийлэнх олонхийг хамрах янзтай болж буй ч, мэдээж АНУ тэгэхгүй нь ойлгомжтой. Дээр нь нэмээд ОНМХ, олон нийтийн санаа бодол, төрийн бус байгууллагуудын зүгээс төр засгуудад дарамт учруулж, асуудал үүсгэж, зарим (явган цэргийн эсрэг задардаг мин хэрэглэхийг хориглох тухай гэрээ байгуулах гэх зэрэг) тохиолдолд нааштай үр дүнд хүрдэг ч, ихэнхдээ төрийн ажлыг саатуулдаг. Үр дүнд нь хамтран ажиллаж буй улс орнууд улам доройтож, хүчээ авч буй даяарчлалын давалгаанд хүчин мөхөсдөх гунигт тавилан эдлэнэ.

Олон талт тогтолцоонд ихэд найдлага тавьж буй хүмүүс болох “зохицуулалт”-ыг дэмжигч өрнөд европынхон өөрсдөө энэхүү тогтолцооны суурь болсон төрийг сулруулаад байгаа нь хачирхалтай хэдий ч хөдөлшгүй баримт юм. Ер нь олныг хэлмэгдүүлэгч, хүнд сурталт, хяхан хавчигч дэглэмүүдийн засаглалын хэмжээлшгүй эрхийг хязгаарлаж, хууль эрхэнд захируулж, зах зээлийн тус дэмээр үр ашгийг нь дээшлүүлэх явдал чухам яагаад хэрэгтэй хийгээд зайлшгүй шинжтэйг хүн бүхэн бараг мэддэг. Гэтэл өнөөдөр дэлхий ертөнц маань төрийн хүч чадал ихэдсэнээс бус, түүний “хүчгүйдэл”-ээс гол төлөв шаналж байна. Хөгжиж буй орнуудад иргэний нийгэм, зах зээлээс гадна ажил хэрэгч хүчтэй төрийн машин үгүйлэгдэж байна. Энэ байдлыг засахгүй бол олон талт шинж нь (ноцтой асуудлаа үндэстнийхээ хэмжээнд шийдвэрлэж чаддаггүй засгийн газар ямар ч хариуцлага хүлээдэггүй тул) бусдад хариуцлагаа тохих аятайхан арга, үл бүтэх зорилго, хэрэггүй механизм болж хувирна. Чухам энд л олон талт тогтолцооноос юу хүсэн хүлээж байгаа болон уг тогтолцоо юуг бүтээж чадах вэ гэдгийн зааг ялгаа харагдана.

Дүгнээд үзье л дээ. Дурбанд болсон дээд хэмжээний уулзалтаас хойш ямар ч шийдвэр гаргасангүй; практикт биелшгүй зорилтуудыг мянганы Тунхаглалаар дэвшүүлэв. Дээр нь сүүлийн арваад жилийн турш НҮБ-аас зохион байгуулсан хэдий ч олигтой үр дүнд хүрээгүй олон арван хурал зөвлөгөөнийг нэмье л дээ: Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг ёсчлон биелүүлсэн хамгийн сүүлчийн тохиолдол л гэхэд бүр 1991 онд Персийн булан дахь дайны тухай тогтоол байсныг санахад л хангалттай. 2001 онд ДХБ-аас Доха-д зохион байгуулж эхэлсэн олон талт хэлэлцээрүүдээс олигтой үр дүн гарсангүй. ДВС-гийн үүрэг роль буурч байгаа нь сайхан мэдээ ч байж болох юм! Дэлхийн банкны зөрчилт, туушгүй бодлого шүүмжлэлд өртөх нь ихэсч, маргаан тарьж байна. Удахгүй гучин тав болж нэмэгдэх Европын холбооны гишүүн хорин долоон улс хэл амаа ололцож чадаагүй л байна. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай Хэлэлцээрийг ил эсэргүүцэгчид ч дуугарсаар...Олон талт ертөнц мандтугай л гэх шив дээ!

Тасралтгүй хурал зөвлөгөөн хэнийг ч сульдааж мэднэ! Гэтэл хүмүүс ийм үлбэгэр тогтолцоотой санал нийлэхгүй, тэр тусмаа “Ирээдүйн товч түүх” номондоо Жак Аттали бичсэнчлэн, тухайн газар нутаг дахь төр засаг болон ардчиллыг устгадаг хирнээ зах зээлийнх нь гадна орших ийм “аврага гүрэн”-тэй эвлэрэхэд бэлэн биш байгаа бол, бид бүхэн харин ч олон талт тогтолцоог дэмжиж, хууль зүйн үндсийг нь бэхжүүлж, үр ашгийг нь дээшүүлэх ёстой болж байна.

...НҮБ-ийг шинэчлэх явдал бол бэрх үйл гэдэг нь тодорхой: энэ байгууллагын бүтцийг өөрчлөх талаар олон янзын хэлбэр, чиг хандлагуудыг санал болгосон илтгэлүүд тоймоо алдсан ч олигтой үр дүнд хүрээгүй л байна. 1919 онд, 1945 онд тус тус баталсан Үндэсний Лигийн дүрэм, НҮБ-ын дүрмүүд бол ялагч гүрнүүдийн боловсруулсан баримт болохыг сануулъя. “Нэгдсэн үндэстний ард түмнүүд, Бид...” хэмээн сүртэй эхэлдэг НҮБ-ын дүрмийн эх бичгийг АНУ-ын Төрийн департаментад эхэлж боловсруулсныхаа дараа л англи, франц, хятад, орос болон уг баримтанд гарын үсэг зурсан бусад дөчин долоон орны төлөөлөгчдийг хэлэлцүүлэгт татан оруулсан түүхтэй. Гэтэл 2000 онд байдал өөр болжээ: НҮБ-ын дүрэмд өөрчлөлт оруулахын тулд • Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн таван орон зөвшөөрч, Ерөнхий Ассамблейн чуулганд оролдцогчдын гуравны хоёр нь саналаа өгсөн байх ёстой юм. Нэг тал нь ялж

нөгөөх нь ялагдал хүлээсэн “Хүйтэн дайн”-ы дараа 1945 оных шиг “дайны дараахь үе” үүсээгүй гэж хэлж болох нь Орос, Америк хоёр урьдынхаараа хориг тавих эрхээ хадгалсаар буйд оршино.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан тус байгууллагын гол бүтцүүдийг, тухайлбал Аюулгүйн зөвлөлийг шинэчлэхийг нилээд хичээсэн билээ. Байнгын гишүүний статус болон хориг тавих эрхийг өөрчлөх тухай мөрөөдөл хоёр шалтгаанаар бүтэлгүйтдэг байна. Нэгдэх нь гэвэл Үндэсний Лигийн дүрмийг болон уг байгууллага доройтоход хүрсэн шалтгаануудыг судалсаны үндсэн дээр эдгээр заалтыг НҮБ-ын дүрэмд оруулсан явдал. Хоёр дахь шалтгаан нь бол байнгын гишүүний статус болон хориг тавих эрх зэрэг байгаагүй бол гишүүн орнууд уг байгууллагыг зүгээр л орхин одох ажээ. Рузвельт, Черчилль, Сталин нарын Ялтад ярьж байсан бүх зүйл өнөөдөр ч санаа зовоосон хэвээрээ байна. НҮБ сул доройтнуудын чуулган болчиж ч мэднэ. Европын хорин долоон орныг нэг нь л төлөөлөх тухай үзэл санаа нь наанадаж Франц, Англи хоёрын дээрх эрхүүдийг алга хийж, цаашилбал эдгээр улс орон ам хэлээ ололцох гэсээр байгаад Европын холбооны төлөөлөл арван арга хэмжээний есд нь оролцож чадахгүй байдалд хүрч мэдэхээр байна.

Өнөөгийн байнгын гишүүд болон атаархуу хөршүүд буюу хориг тавих эрхгүй шинээр сонгогдсон байнгын гишүүдийн зүгээс гарч болох дургүйцлийг үл хайхран (гэхдээ л бас тэд зөвшөөрсөн тохиолдолд), хориг тавих эрхтэй тав юмуу зургаан (Япон, Энэтхэг, Герман бие дааж, латин америкийн улсууд, африкийн орнууд, арабын ертөнц нэг нэг төлөөлөлтэй байх, гэхдээ сүүлчийн гурав нь бүс нутаг дотроосоо шалгарч гарч ирэхээр) шинэ байнгын гишүүнтэй болж болох л байх. 2004 онд Зөвлөгч нарын бүлгийн бэлтгэсэн илтгэлд Аюулгүйн зөвлөлд шинээр байнгын гишүүн нэмж болох бүрэн боломжтой тухай дурьдсан нь хагас алхам юм. Хориг тавих эрхийн талаар ч хязгаарлах гэх зэрэг саналууд гарч байв: зарим асуудлаар ганц саналаар бус хоёроос гурван саналд үндэслэн хориг тавьж, түүний үйлчлэх хугацааг ч бас тодорхой тогтоож заахад хүрнэ. Аль нэг оронд ямар нэг тусламж яаралтай үзүүлэх зайлшгүй тохиолдол гарахад дэлхийн ареапаг (Эртний Афины шүүх хянах дээд байгууллага, Эрхтэн дархтнууд Арес уулнаа чуулж ийм шийдвэр гаргадаг байснаас улбаалан үүссэн нэр томъёо. Энд нэр хүндтэй байгууллагууд гэсэн утгаар хэрэглэжээ -А.Э.)-ийн шийдвэрээр бүрэн эрхт тусгаар тогтносон байдалд нь заналхийлэл учруулалгүй нарийн тогтсон хугацаа (гурван сараас хагас жил хүртэл хугацаанд нэг хоёроос хэтрэлгүй)-г мөрдөхийг би хувьдаа санал болгож байна. Энэ тохиолдолд “үзүүлсэн арга хэмжээний төлөө хүлээх хариуцлага” гэсэн нэр томъёолол дээр НҮБ зогсч байна. Ихэнх байнгын гишүүд ийм огцом өөрчлөлтийн тухай сонсохыг ч хүсэхгүй байгаа хэдий ч шинэ түүхэн нөхцөл байдалд тохируулан уг төслийг боловсруулж олонд танилцуулж, урагшлуулах шаардлага гарцаагүй гарч ирж байгаа ба хэрвээ энэ нь бүтвэл амьдралд хэрэгтэй өөрчлөлт шинэчлэлийг эсэргүүцдэг АНУ, Орос, Хятад зэрэгт хүндхэн дарамт үзүүлэх хүртэл үргэлжлүүлэх шаардлага гарна.

НҮБ-ын тогтолцоог шинэчлэх бусад алхмууд ч бас хэрэгтэй байна. Итгэл найдвар нь доройтоод байсан Хүний эрхийн Комиссыг 2005 онд зарим талаар шинэчилсэн боловч урьдын нэр хүнд нь сэргээгүйгээс үзэхэд суурь зарчмуудаа ноцтой зөрчсөнийх болов уу гэж бодож байна. Харин Эдийн засаг нийгмийн зөвлөлийн өсөн нэмэгдэж буй нэр нөлөө нь худалдаа, хөдөлмөрийн эрх, экологийн (Дэлхийн худалдааны байгууллага, Хөдөлмөрийн дэлхийн байгууллага болон Хүрээлэн буй орчны талаар байгуулах шаардлагатай Дэлхийн байгууллагууд дундын) салбарууд дахь чухал шийдвэрүүдийг зөвшилцөх дээд хэмжээний шүүн хэлэлцэх дамжлага шат байж болох боломж байгааг харуулж байна. Зээлдэгч орнууд хямралт байдлаасаа хэрхэн гарч эдийн засаг нь ямархуу байгааг танаддаг Ажиглагчдын зөвлөлийн идэвхи чармайлт бүрэн сэргэж буй нь ойр зэргэлдээ аль нэг гүрэнд нь асуудлыг шийдвэрлүүлэхээр оноох байдлаас түдгэлзэх боломжийг бий болгов. Анри Налле¹⁷⁷ бид хоёр жилд нэг удаа иргэнийн

¹⁷⁷ 90-ээд онд францын хууль зүйн сайдаар ажиллаж байсан нэрт улс төрч.

нийгмийн асуудлаар чуулж, Ерөнхий Ассамблейд санал хүсэлтээ гаргадаг Дэлхийн зөвлөлдөх зөвлөлийг байгуулах нь зайлшгүй чухал гэж үзэж байна. Энэ зөвлөлд хэн орж болох вэ? Итгэл найдвар даах эсэх нь янз бүр, төрийн бус олон байгууллага байдаг ч, бүгд л асуудлыг иж бүрнээр нь шийдвэрлэх өөрийн гэсэн нотолгоот шалгууруудаа боловсруулсан институциуд тул тэдгээрийг нь нэгтгэн дүгнэх явдал тийм ч хэцүү биш байх. Бреттон-Будийн хэлэлцээрээр байгуулагдсан байгууллагуудын дүрмийг өөрчилж, үйл ажиллагааг нь сайжруулж болно гэж үзэж байна. Дэлхийн валютын санд АНУ 17.08%, Япон 6.13%, европын хорин таван улс 32% (түүний дотор Герман 5.99%, Франц 4.95%) –ийн санал тус тус эзэлдэг нь “Их долоо”-гийнхны саналыг 45% болгож байгаа юм. 2006 оны есдүгээр сард Өмнөд Солонгос, Хятад, Мексик, Турк улсуудын эзлэх байр суурь дээшлэв. Дэлхийн валютын сан дахь саналын тоо нь уг байгууллагын гишүүн орнуудын санхүүгийн оролцоогоор тодорхойлогддог. Эдийн засаг нь эрчимтэй хөгжиж байгаа болон хөгжиж байгаа орнуудыг орчин үеийн нөхцөл байдалд нь нийцүүлэн төлөөллийг бүрдүүлэхийн тулд хувь болон саналын тоог тогтоох тогтолцоог үндэсээр нь өөрчлөх хэрэгцээ шаардлага гарч байна.

Европчууд болон дэлхий дахины зүүний хүчнийхэн НҮБ-ын хүрээнд Дэлхийн хүрээлэн байгаа орчны байгууллага юмуу Хүрээлэн буй орчны байгууллага гэдгийг байгуулах зайлшгүй хэрэгцээ байгааг ярьцгаах болов. 1992 онд Рио-де-Жанейрод болсон бага хурал дээр энэ саналыг Франц улс дэвшүүлж, 2001 онд Лионель Жоспен бас ярьж, 2002 онд Иоханнесбургд болсон Дэлхийн саммит дээр Жак Ширак дахин сөхөн гаргаж, 2007 оны уулзалт дээр бас дэвшүүлж байсан билээ. Энэ байгууллагын дүр төрх бүрэн гүйцэд хараахан тодроогүй хэдий ч хүрээлэн буй орчны асуудлаар байнга үйл ажиллагаа явуулдаг чуулган байж, олон улсын бусад байгууллага (ОУВС, Дэлхийн банк, ДХБ)-ын итгэлт түнш болох найдвар төрүүлээд байна. Шинэ байгууллагад хүрээлэн байгаа орчны талаарх олон талт гэрээ хэлцлүүд (Киотын протокол, Хүрээлэн буй орчны талаарх НҮБ-ын Хөтөлбөрүүд, хөгжиж буй орнуудад туслах, ажиглах, сургалт явуулах Хүрээлэн буй орчны дэлхийн сан) болон янз бүрийн тусгай гэрээнүүдийн нөхцлүүд хэрхэн хэрэгжиж буйг хянах хөрөнгө хүч, мэрэгшсэн шинжээчидтэй байх ёстой.

Цөмийн бодлогын салбарт гэхэд л үл дэлгэрүүрэх тухай шинэ гэрээ нэн шаардлагатай болоод байна. Наанадаж цөмийн түлшний хаягдлыг зайлуулах асуудлыг шийдвэрлэж, Умард Солонгостой шийдсэн шигээ Ирантай хэл амаа ойлголцож, Израиль, Энэтхэг, Пакистан зэрэг “мутраа хайрлах дургүй” улстай яаж харилцахаа тодорхой болгож, “энхийн атомын” хөтөлбөрийг амьдралд хэрэгжүүлэх, энэ талаарх технологийг дамжуулах нөхцлөө тод томруун болгох шаардлага нүүрлээд байна. Товчхон хэлэхэд гэрээг бодит байдалд улам ойртуулж, түүний заалтууд “энхийн” эрчим хүчний хөгжилд түлхэц болж, дайны зорилгод ашиглахыг бүрэн зогсоох талаар шаардлагатай бүхнийг хийх хэрэгтэй юм.

Энэ бүх өөрчлөлт шинэчлэл нь олон үндэстний тогтолцоог улам хууль ёсны, ажил хэрэгч болгоход чиглэх ёстой. Худал тайлбарт автахгүйн үүднээс: эдгээр байгууллагууд бол богино хугацаагаар бүрэн эрхээ төлөөлүүлэхээс бусад тохиолдолд гишүүн орнуудынхаа засгийн газрыг орлох ёс ч үгүй, чадах ч үгүй; Хүч хэрэглэх явдал нь НҮБ-ын дүрмийн VII бүлэгт заасны дагуу Аюулгүйн зөвлөлийн онцгой эрх дархад хамаарах зүйл; олон улсын санхүүгийн хямралуудыг ДВС шийдэх ёстой гэдгийг шууд хэлчихье. Өөрөөр хэлбэл, олон улсын байгууллагууд нь аль нэгэн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд хамаатай гэрээ хэлэлцээр хийх цар хүрээг засгийн газруудад тогтоож өгөх үүрэгтэй билээ.

Ийм илт зүйлсийг юуны учир нуршин тоочно вэ? гэвэл европын олон нийтийн зарим төлөөлөл дэлхий ертөнцийн бурханлиг бүтцэнд итгэх нь хэтэрч, олон талт тогтолцоо бол өөрийгөө хангаад байх шинжтэй төдийгүй янз бүрийн улс орнуудын амиа хичээх үзэлтэй хийх тэмцэлд хэрэг болчихуйц, үндэстнээс дээгүүр бүтэцтэй гэж үзэцгээх болжээ. Хороод, ерөнхий захирлууд, олон тооны хамтран зүтгэгчид анхны алхмаасаа эхлээд л өөрсдийнхөө эрхийг хууль ёсных хэмээн хүлээн зөвшөөрүүлэх асуудалтай

тулгарцгаав. "Олон улсын архитектур" гэгч илэрхийлэл хуурамч төдийгүй, ямар ч "архитекторч" алга! "Тархин төв"-өөр удирдуулах зүйл нь ч алга.

Олон улсын институциудын хүсэл мөрөөдөл, бодит байдал хоёр хоорондоо хол зөрөөтэй ажээ. "Их найм" болчихоод байгаа "Их долоо" нь дүрэм журамгүй хирнээ (заримдаа ОНМХ-ээр дамжуулан өсгөдөг) нэр нөлөө нь Хятад, Энэтхэг хоёроос бусад дэлхийн аж үйлдвэржсэн том гүрнүүдийн жил тутмын уулзалтаар тодорхойлогдож ирлээ. Ер нь эцэстээ үндэстэн лидерүүдийн бүлэглэл ямархуу байх вэ? Энэ нь шинжээчдийн үзэж буйгаар Аюулгүйн зөвлөл (өргөтгөсөн байдлаар), "Их долоо-найм" (өргөтгөсөн байдлаар), Олон улсын валют, санхүүгийн хороо (Түр хороо байсан) зэргийн завсрын шинжтэй байх бололтой. "Эдийн засгийн аюулгүйн зөвлөл" хэмээн Жак Делормын нэрлэж байсан тэр зүйл болох бололтой.

Олон үндэстний институциудыг зайлшгүй шинэчлэх шаардлагатай нь нэгэнт илт болоод байна. Энэ үйлийг гүйцэлдүүлээгүй цагт агшин зуурын ашиг сонирхолдоо хөтлөгдсөн нөгөө зах зээл маань бараг юунд ч захирагдахгүй дэлхий ертөнцийг залж чиглүүлэх болж байна.

Францчууд уриа лозунд дуртай л даа. Ямар сайндаа л, бүтэц, туйл хоорондын холбоо, олон талт тогтолцоотой харьцах харилцаа зэрэг нь огт тодроогүй байгаа "олон туйлт" ертөнцөд ихэд найдаад байхав. Бидний хувьд энэ дэлхий дээр өөрийн чадал чинсаанд таарсан үүрэг ролио олж, америкийн нэгэн туйлт тогтолцооны савраас ангижирч, хүчирхэг европ туйлын дотор оршингоо, аль нэг тал руу хэлбийлгүй шийдвэртэй нөлөө үзүүлж чаддаг болж сурах л үлдээд байна. Гэтэл бас зоримог бус Европ доторх Францын нэр нөлөө суларч, бидэнгүйгээр олон туйлт ертөнц маань бүрэлдэх юм бол энэ схем бидний давуу тал байхаа болино! Тэгэхдээ их гүрнүүдийн хоорондох тэнцвэрт байдлыг тогтооход хир хэцүү байдаг шиг туйлуудын хоорондох тэнцвэрт байдал ч ярвигтай тул энэхүү тогтолцоо тогтвортой байх баталгаа бас алга...Тодруулах шаардлагатай өөр нэг зүйл бол Ширакийн хэлээд байгаа шиг олон туйлт ертөнц бол гарцаагүй тулчихаад байгаа зүйл үү? гэсэн асуулт юм. Хэрвээ тийм бол энэ зүйлийн давуу талыг дээдэлснээрээ бид, уг ойлголтыг үзэн яддаг америкчуудын сэтгэл санааг дорд үзсэн болохгүй. Эсвэл бид Бразил, Орос, Энэтхэг, Хятад, Өмнөд африк болон бусад орныг бүрэлдхүүндээ багтаасан байдлаар түүнийг бүтээхэд хүрээд байна уу?

Эдгээрийн аль ч тохиолдолд Аюулгүйн зөвлөлийн өргөтгөсөн бүрэлдхүүнд олон туйлт ертөнц өөрийн төлөөллөө байлгах ёстой болно. Хамгийн сонирхолтой нь Төв Ази, Зүүн Ази, Энэтхэг, Латин Америк, Ойрхи Дорнод, Африкийн орнуудын хооронд эрчим хүч болон бусад чиглэлээр Америкийн ч, Европын ч оролцоогүйгээр шууд холбоо улам хурдан тогтон хөгжиж, энэхүү олон туйлт ертөнц биднээс хамааралгүйг харуулаад байна!

Төрийн үндсийг цаашид сулруулж, бусниулснаар дэлхийн хөгжлийг урагшлуулахгүй гэдгийг олон талт чанарыг өмөөрөгчид, өөрчлөлт шинэчлэлийг дэмжигчид ямар ч гэсэн ойлгох хэрэгтэй. Даяарчлалын хэмээн дуулиан тариад буй өдөөлтөд хариу өгөх үүднээс зайлшгүй хийх ёстой зарим үйлдлийг энэ өнцгөөс авч үзье.

Экологийн талаарх Киотын протокол нь дэлхийн олон нийтийн өмнө төр гүрнүүд сайн дураараа авсан амлалт юм. Засгийн газрууд нь тавьсан зорилтоо хэрэгжүүлэх үүднээс эрдэмтдийн нээлт, үйлдвэр аж ахуйн газруудын тооцоонд үндэслэн урамшууллын болон албадлагын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд хүрч, өөрсдийнхөө өсөлтийн эх сурвалж бол экологийн конверси¹⁷⁸ (техник утгаараа) болохыг сая л нэг ойлгоцгоож эхлээд байна. Энэ байдал бас хүмүүсийн эрүүл мэндэд химийн бодисын, тэр тусмаа пестицидийн учруулж буй нөлөөг тогтмол үнэлж хэвших хийгээд аюултайгаас нь татгалзаж дадах зэрэг "химийн бодисоос үүдэлтэй өвчин согогийн тахал" гэж эрүүл

¹⁷⁸ Латины *conversio* -өөрчлөлт, хувиралт гэсэн үг- А.Э.

мэндийн салбарын томоохон хэвлэл болох "Ланцет"-ийн нэрлэсэн зүйлсийг арилгах талаар санал дэвшүүлдэг европын төдийгүй Дэлхийн REACH¹⁷⁹ комиссд хамаарах юм. Ядуурлын асуудлыг (Дэлхийн хүнсний хөтөлбөрийн хүрээнд жаран сая гаруй хүнийг тэжээж буй яаралтай тусламж энд хамаарахгүй) тусламжаар биш дэлхийн баялгийг өсгөж (хамгийн гол нь зөв хувиарлаж) байж, өөрөөр хэлбэл, баян орнуудын хамтын ажиллагаан дахь том үндэстнүүдийн хэмжээнд хэрэгжүүлж буй өсөлт хөгжлийн эдийн засгийн бодлогоор дамжуулан шийдвэрлэх нь ойлгомжтой. Ингэж байж л бид ойрын арваад жил улам нэмэгдэх хандлагатай байгаа цагаачлалын урсгалыг хүмүүнлэг байдлаар зохицуулах боломж олно. Олонхи хөгжиж буй орнуудад наад захын аюулгүй байдал, нийгмийн эв нэгдэл, үндэстний мэдрэмжийг хангаж чадахуйц сайн бүтэцжсэн төр үгүйгээс болж, бүхий л алдаа дутагдлын гол буруутан гэгддэг данхгар хүнд суртлаас ч илүү ноцтой хоцрогдол дагуулах болно.

Тахалтай хийж буй тэмцэл ч гэсэн ДЭМБ (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага)-ын анхааруулгыг тухайн улсын засгийн газрын хариуцсан нутаг дэвсгэр дэх орон нутгийн засаг захиргааны албадууд яаралтай хэл дуулгаж, нийгмээ бэлтгэж чадаагүй тохиолдолд үр дүнд хүрэхгүй. Энэ байдал бас далд эдийн засгийн: НҮБ-ын судалгаагаар жилд 500 тэрбум долларын эргэлттэй гэж гарсан хар тамхины худалдаа; зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, бохир мөнгө (ОУВС-ийн үзэж буйгаар нийт хэмжээ нь дэлхийн ДНБ-ий 2-5%-г эзэлдэг аж) угаах гэмт хэрэг гэх зэрэгтэй хийж буй тэмцлийн бүх хэлбэрд хамаарна. Асуудлыг нийгмийн сайн сайхны тусын тулд нааштай шийдэхэд үндэстний хийгээд европын цагдаа, гааль, шүүх, түшмэдийн аппаратын эвсэг ажиллагаа нэн чухал байна.

Дэлхий ертөнц дэх соёлыг дундачлах үзлээс татгалзаж, соёлын олон янз байдал болон хосгүй шинжийг (тэр тусмаа хэлний) хамгаалах үйлс нь худалдааны талаарх ерөнхий хуулиудаас соёлынхыг тусгайлан авч үзсэн олон улсын хууль эрхийн актуудад тулгуурлаж байж л олон төрлийн байх боломжоо хадгалах болно. 2005 оны аравдугаар сарын 20-нд Соёлын олон янз байдлыг хамгаалах, хөгжүүлэх тухай Конвенци байгуулах тухай Франц улсын гаргасан саналыг ЮНЕСКО дэмжсэнээр 148 улс гарын үсгээ зурж баталгаажуулсан билээ: энэхүү Конвенцийн бүтцийг бүтээхдээ тухайн тодорхой улс орны хууль тогтоомж, засгийн газрын тушаал шийдвэрүүдэд үндэслэсэн хэдий ч уран бүтээлчдийн хувь нэмэр, соёлын байгууллагуудын хүчин чармайлтгүйгээр цаас хэвээр үлдэх нигууртай.

"Иргэншил хоорондын мөргөлдөөн"-д янз бүрийн хариулт өгөх нь элбэг. Үүнийг сүшиг бишрэл "биелэх" тухай хорон онол төдий зүйл хэмээн үзэж, индэр дээрээс муу санааг нь илчлээд хэлчихээр илбэдүүлсэн мэт энэ ертөнцөөс алга болж, зүггүй байгууллагууд ч ийм онолоор далайлган хашгирдагаа больцгооно гэж боддог нөхөд бий. Мөн бас "соёл хоорондын яриа хөөрөө" гэж хэлэх дуртай олон улсын инстициуд ч бий. Гэтэл над мэт бодит аюул занал байгааг олж хардаг хүмүүс болохоор "мөргөлдөөн"-ийг яриа хөөрөө маягаар биш, улс төрийн шийдвэр гаргаж зохицуулах ёстой гэж товч тодорхой хариулдаг. Гэтэл төр хүчлэхгүй бол ийм шийдвэрт хүрэхэд бэрх. Өрнөд болон араб-исламын ертөнц хоорондын харилцааг олон арван жил булингартуулсан Израиль Палестин хоёрын сөргөлдөөнийг бусад хөршүүд нь оршин тогтнол, хил хязгаарыг нь үг дүүгүй хүлээн зөвшөөрсөн, аюулгүй байдлынх нь баталгааг их гүрнүүд, юуны өмнө АНУ хариуцсан, Израилийн төртэй зэрэгцэн оршиж буй Палестины зүй ёсны төргүйгээр шийдэх аргагүй билээ. Зохицуулалтын хүрээ (Клинтоны санал, Табегийн хэлцэл, Рабу-Бейлин нарын Женевийн хэлэлцээр гээд) нэгэнт тодорхой болж, арабын гудамж дүүргүүд, израилийн хот суурингуудад энхийн хүслэн бүрдэх нь дөхөж,

¹⁷⁹ Европын холбооны хүрээнд байгуулсан REACH (Registration, Evaluation and Authorisation of Chemicals) комисс нь химийн бодисын аюулгүй байдлыг тогтоох, бүртгэх, зөвшөөрөх, хориглох үйл ажиллагааг эрхэлдэг.

удирдагчид аливаа саад бэрхшээл, үймээн самуунаас үл эмээн, хэлэлцээрийн ширээний ард зориг шулуудан сууж, уг үйлийг бүтээх л “үлдэв” бололтой. Хоёр гурван дайсагнагч, этгээд улс гүрнүүдээс бусад бүх дэлхий тэр аяараа энэ үйлсэд нь тус дэм үзүүлнэ. Палестин-Израилийн сөргөлдөөнийг шийдвэрлэх үйлсдээ АНУ эргэж орохгүй бол Ойрхи Дорнод дахь нөхцөл байдал муудна гэж Ирак дахь байдлын талаар тавьсан илтгэлдээ Джеймс Бейкер тэмдэглэснийг олзуурхууштай.

Бид, хууль эрхийн чадамжтай, орчин үеийн, шинэчлэгдсэн, үнэнхүү чухал зорилтууд дээрээ төвлөрч чаддаг, ардчиллын үйл явцад идэвхийлэн оролцдог тийм төрүүдийн тухай ярьж байгаа гэдгээ санацгаая. Бид өөрсдийн ачаа тээшээ “олон улсын хамтын нийгэмлэг”, НҮБ, бурхан тэнгэр зэрэгтээ даатгаж болохгүй гэдгийг ойлгох ёстой. Суверенитет чанараасаа татгалзсан төр гүрнүүдэд европын ч юмуу, дэлхийн ч юмуу илүү дээд эрэмбийн засаглал аяндаа өвлөгдөх ч үгүй, аль нэг шинэ ардчилсан орон зайд “очих” ч үгүй. Харин нэг л зүйл “учрах” бөгөөд тэр бол зах зээл байх болно. Иймд төр урьдын адил зайлшгүй ажээ. Үүнийг ажсан Сами Козн¹⁸⁰ 2003 онд “төрт ёс хадгалагдсаар” гэж халагласан гэдэг. Неоконсерватор асан Фрэнсис Фукуяма бүр ч цаашилж, 2004 онд “Төрийг бүтээхүй” номоо гарган, төрийг гаднаас нь тохинуулах боломжид эргэлзсэн янзтай хэдий ч, төр бол зайлшгүй болохыг нотлон бичжээ.

Энэ дэлхийг сайхан болгоход үндэстнээс дээгүүр, тэнгэр язгуурын мөн чанар ч тэр, төрийн аль нэг чиг үүрэг ч тэр тус нэмэр болохгүй. Үүнийг зөвхөн бид хамтдаа л хийж чадна. Биднийг олон улсын хамтын нийгэмлэг ч тэр, НҮБ ч тэр орлож үл чадна. Төрийг гарцаагүй мөхөж сөнөнө хэмээн үздэг үеэ өнгөрөөсөн улиг домог болсон, үндэстнээс хальсан философийн үзлийг таягдан хаях болжээ. Философийн ийм үзлийг зарим либераль үзэлтнүүд, европын зүүнтэн агснууд, евроинтеграцийг талархагчид, олон талт ертөнц өөд тэмүүлэгч идеалистууд, бас европыг өөрсдийн үйл хэргээрээ улс төрийн мухардалд оруулсан нөхөд баримталж ирсэнийг хэлэх юун.

¹⁸⁰ Сами Козн – Олон улсын судалгааны Парис дахь төвийн захирал. Дэлхийн улс төрийн бодлогын талаар олон бүтээл туурвисан эрдэмтэн. 2006 онд “Төрүүдийн эсэргүүцэл: даяаршилтай тулгарсан ардчилал” ном нь хэвлэгдсэн